



ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ
СТРАТЕГИ СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭН

ДҮРВЭГСДИЙН АСУУДАЛ



Улаанбаатар хот

2023 он

ДҮРВЭГСДИЙН АСУУДАЛ

Эрхлэн хэвлүүлсэн:	ССХ-ийн Олон улсын цэрэг, стратегийн аюулгүй байдлын судалгааны төв
Редактор:	З.Болдбаатар (Sc.D), С.Буянхишиг
Хэвлэлийн эхийг бэлтгэсэн:	С.Буянхишиг
Хэвлэлийн хуудас:	4

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	4
ОРШИЛ	5
НЭГ. ДҮРВЭГСДИЙН ОЛОН УЛСЫН	
ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ	
1.1. Дүрвэгсдийн талаарх ойлголт, нэр томъёоны асуудал	7
1.2. Дүрвэгсдийн олон улсын эрх зүй	11
1.3. Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн олон улсын байгууллагуудын чиг үүрэг	14
ХОЁР. ДҮРВЭГСДИЙН АСУУДЛААРХ ОЛОН УЛСЫН	
ТУРШЛАГА, СУРГАМЖ	
2.1. Дүрвэгсдийн асуудлаарх олон улс, бүс нутгийн нөхцөл байдал	18
2.2. Олон улсын болон үндэсний хэмжээнд дүрвэгсдийг хамгаалах асуудал	21
2.3. Дүрвэгсдийн урсгалын сөрөг нөлөө	25
ГУРАВ. ДҮРВЭГСЭД БА МОНГОЛ УЛС	
3.1. Дүрвэгсдийн асуудлаарх Монгол Улсын эрх зүйн орчин, туршлага сургамж	27
3.2. Монгол Улсад дүрвэгсэдтэй холбоотой үүсэж болзошгүй нөхцөл байдал, төрөөс баримтлах бодлого	30
ДҮГНЭЛТ	34
ХАВСРАЛТ	36

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ДАЭДКГ	Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн дээд комиссарын газар
ЗХУ	Зөвлөлт Холбоот Улс
ОХУ	Оросын Холбооны Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ӨМӨЗО	Өвөр Монголын өөртөө засах орон
БНКаЗУ	Бүгд Найрамдах Казахстан Улс
БХЭШХ	Батлан хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэн

ОРШИЛ

Дүрвэгсдийн асуудал нь дэлхийн хамтын нийгэмлэгийн өмнө тулгамдаж буй хамгийн төвөгтэй асуудлын нэг бөгөөд тавиад онд дүрвэгсдийн ихэнх нь европчууд, жар, далаад онд африкчууд, наяд онд латин америкууд байсан бол өнөөдөр ихэнх нь Ази, Африк, Ойрх дорнодын дүрвэгсэд болоод байна. Аюул заналхийллийн улмаас аргагүйн эрхэнд амь зулбаж хоргодох газар хайж дүрвэн дайжсан хүмүүсийг хамгаалах нь хүн төрөлхтний хүнлэг ёсны эртний уламжлал, үнэт зүйл бөгөөд эдүгээ олон улсын хамгаалалтын салшгүй нэг хэсэг болжээ.

Дүрвэгсдийг хамгаалах олон улсын чиг үүрэг нь дүрвэгсдийг буцаахаас урьдчилан сэргийлэх, орогнол хүсэгчийн хүсэлтийг шийдвэрлэхэд туслах, хууль зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх, дүрвэгсдийн аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх, сайн дурын үндсэн дээр эх оронд нь буцаахад болон нүүлгэн шилжүүлэхэд туслалцаа үзүүлэх явдал юм.

Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай 1951 оны конвенцыг НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн дээд комиссарын газар 70 гаруй жил тууштай хэрэгжүүлж, олон улсад дүрвэгсдийг хамгаалах эрх зүйн орчныг бэхжүүлэхэд гол үүрэг гүйцэтгэж байна. Хамгийн сүүлд 2016 оны есдүгээр сард баталсан Дүрвэгсэд, цагаачдын тухай Нью-Йоркийн тунхаглалд НҮБ-ын гишүүн 193 улс бүгд нэгдсэн нь дүрвэгсдийг хамгаалах үндсэн зарчмыг хүн төрөлхтөн хүлээн зөвшөөрч байгааг харуулж байна.

2023 оны байдлаар Украин, Сири, Афганистан, Палестин, Өмнөд Судан, Сомали, Мьянмар зэрэг улсын 108 сая хүн мөргөлдөөн, хүчирхийлэл, хавчлагад өртөн орон гэрээсээ дайжин дотоод гадаадад дүрвэсний гуравны нэг орчим нь хил давсан байна. Мөн нийт дүрвэгсдийн талаас илүү хувийг 18 нас хүртэлх хүүхэд, залуус эзэлж байна.

Дүрвэгсдийг хүлээн авах улсад учирдаг нийтлэг бэрхшээл нь дүрвэгсэдтэй холбогдсон онцгой нөхцөл байдлыг зохицуулах, эмэгтэй дүрвэгч, хүүхэд, гэр бүлийг хамгаалах, дүрвэгч нэрээр орж ирсэн хүн тус бүрийн статусыг тогтоох, дүрвэлтийн асуудлаар урт хугацааны баттай шийдлийг олох явдал байна.

Дүрвэгсэд нь хяналтгүй шилжилт хөдөлгөөнийг бий болгох, хууль бусаар хил нэвтрэх, гэмт хэрэг өсөх, эдийн засгийн болон байгалийн баялаг эзэмших талаар өрсөлдөгч болох, нутгийн иргэдтэй зөрчил, мөргөлдөөн үүсгэх зэргээр хүлээн авагч улс, бүс нутагт сөргөөр нөлөөлж байна. Үүний улмаас зарим улс оронд үндэсний аюулгүй байдал, эдийн засаг, хүн ам зүйн эрх ашгийн үүднээс дүрвэгсдийн орогнол авах эрхийг хязгаарлах, хил хязгаараа хаах, цагдан хорих, хууль эрх зүйн болон процедурын саад тогторууд тавих асуудлууд ажиглагдаж байна.

Тиймээс Дүрвэгсэд, цагаачдын тухай 2016 оны Нью-Йоркийн тунхагалд үндэслэн, дүрвэгсдийг хүлээн авч буй орнуудад учирч буй дарамт шахалтыг багасгах, хамтран ажиллах, тусламж дэмжлэг үзүүлэх зорилготой Дүрвэгсдийн дэлхийн гэрээг НҮБ-аас 2018 онд баталсан.

Цаашид олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс дүрвэгсдийн асуудлыг удаан хугацаанд тогтвортой шийдвэрлэх зорилгоор эх оронд нь буцаахгүй байх зарчмаас татгалзаж, тэднийг сайн дурын үндсэн дээр нутаг буцаах, нийгэмшүүлэх, гуравдагч орны дэмжлэгт тулгуурлах зэрэг шинэ арга замыг эрэлхийлж байна.

Энэхүү эмхэтгэлд дүрвэгсдийн талаарх олон улсын эрх зүйн үндэс, орогнол олгох, хамгаалах тогтолцоо, туршлага сургамж, Монгол Улсын эрх зүйн орчин, дүрвэгсэдтэй холбоотой үүсэж болзошгүй нөхцөл байдал, төрөөс баримтлах бодлого зэргийг орууллаа.

Тус эмхэтгэлийг зөвхөн албаны хэрэгцээнд зориулан Стратеги судалгааны хүрээлэнгээс эрхлэн гаргав.

I ДҮРВЭГСДИЙН ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

1.1. Дүрвэгсдийн талаарх ойлголт, нэр томъёоны асуудал

Олон улсын болон үндэсний эрх зүйн баримт бичгүүдэд дүрвэгч, орогнол хүсэгч, цагаач, дотоодод шилжин явагч, харьяалалгүй хүн, давхар иргэншилтэй хүн, дамжин өнгөрөгч, түр ирэгч, хувийн хэргээр оршин суугч, албан хэргээр оршин суугчийн талаар албан ёсны тодорхойлолтууд тусгагдсанаас гадна судлаачдын дунд тэдгээрийн талаар албан бус нийтлэг ойлголт түгээмэл байна.

Дүрвэгсэд нь дайн, зэвсэгт мөргөлдөөн, хямрал, байгалийн гамшиг зэрэг амь насанд аюул заналхийлсэн нөхцөл байдлын улмаас аргагүйн эрхэнд оршин суугаа газраа орхин өөр улсын нутаг дэвсгэрт бөөнөөрөө зугтан ирсэн хүмүүс юм. Орогнол хүсэгч нь улс төрийн хавчлага, мөрдөн мөшгөлт зэрэг хүний эрхийн зөрчлийн улмаас ганц нэгээрээ аль нэг улсад орогнохоор ирсэн дүрвэгч статусаа хүлээж байгаа хүнийг хэлдэг.

Тухайн улсад бөөнөөрөө орж ирсэн дүрвэгсдийг бодит нөхцөл байдлын улмаас шууд хүлээн зөвшөөрч, дүрвэгчийн статус олгодог бол орогнол хүсэгчийн асуудлыг шүүх, төрийн тэргүүн зэрэг эрх бүхий байгууллагууд нь удаан хугацаанд шийдвэрлэдэг онцлогтой.

Цагаачийн тухай олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хууль ёсны тодорхойлолт байхгүй ч тэдгээр нь ажил хийх, суралцах, эсвэл гэр бүлтэй болох хүсэлтэй учраас иргэний эрхээ эдлэн сайн дурын үндсэн дээр эх орноо орхин гардаг тул орогнол хүсэгч, дүрвэгч биш. Харин орогнол хүсэгч, дүрвэгч нь улс төрийн үймээн самуун,

хүчирхийлэл, байгалийн гамшиг, хүний эрхийн ноцтой нөхцөл байдлын улмаас эх орноо орхин гарсан хүмүүс болох юм.

Зарим улс орон эдийн засгийн шалтгаанаар цагаачдын эрхийг хязгаарлах, нутаг дэвсгэртээ оруулахгүй байх, байгалийн гамшигт өртсөн бүс нутгаас ирсэн дүрвэгсдийг цагаачид хэмээн үзэх тохиолдол байдаг. Гэвч цагаачдыг тухайн улсын Засгийн газар арьс өнгөөр ялгаварлан гадуурхах, үзэн ядах, хүчирхийлэл, мөлжлөг, албадан хөдөлмөрөөс хамгаалах, хууль ёсны шалтгаангүйгээр баривчлахгүй байх, эх оронд нь албадан буцаахгүй байх үүргийг дүрвэгсдийн нэгэн адил олон улсын хүний эрхийн хуулиар хүлээдэг.

Гадаадад цагаачлагч /emigrant/ нь өөрийн эх орноосоо аж амьдралаа сайжруулах зорилгоор өөр улс руу шилжин явж буй хүнийг хэлэх бол цагаач нь /migrant/ нь тухайн улсад байнга буюу түр хугацаагаар амьдарч байгаа, оршин суугаа улстайгаа нийгмийн нягт харилцаа тогтоосон, хүлээн авагч улсынхаа оршин суугч гэж тооцогддог гадаад улсын иргэнийг хэлнэ. Цагаач нь аль нэг улсад амьдрахаар хууль ёсны дагуу болон хууль бусаар ирсэн хүн бөгөөд тэдгээр нь харьяалалгүй /apatride/, давхар иргэншил, харьяалалтай /bipatride/ байж болох талтай.

Цагаачдын асуудлыг Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага, орогнол хүсэгчдийг Хүний эрхийн байгууллагууд, дүрвэгсдийг НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал хариуцсан дээд комиссарын газар голлон хариуцдаг.

Дайн дажин, гамшиг, хямрал, ган зуд зэрэг давтагдашгүй хүчин зүйлийн нөлөөгөөр улсын хилээр нэвтрэлгүй, байнгын байрлалаа орхин дотооддоо дүрвэн явагсдыг дотоодын шилжин явагчид гэнэ.

Ган, зуд, цөлжилт, хэт халалт, эрс хүйтрэлт, далайн түвшин өндөрсөж хуурай газар, арлууд живэх зэрэг байгаль цаг уурын өөрчлөлтөөс улбаалан дүрвэгсдийг экологийн дүрвэгсэд гэнэ.

Цагаач нь дүрвэгсдээс ялгаатай нь тэд өөрийн улсын хамгаалалтыг үргэлжлүүлэн эдэлсээр байдаг бол орогнол хайгч нь олон улсын хамгаалалтыг эрэлхийлж байдаг.

Хүүхэд цэрэг гэдэг ойлголтод, 18 нас хүрээгүй охид, хөвгүүдийг аль нэг улсын зэвсэгт хүчин, зэвсэгт бүлэглэл дайн байлдаан тулаанд ашигласан байдлыг хамруулдаг бол хамгаалалтгүй хүүхэд нь эцэг

эхээсээ салсан, бусад хамаатан садан, анхаарал халамж тавьдаггүй орхигдсон хүүхдүүдийг хэлнэ.

Дүрвэгсдийн талаарх албан ёсны эрх зүйн тодорхойлолтууд

Дотоодын шилжин явагч /internally displaced persons/ гэж зэвсэгт мөргөлдөөн, хүчирхийллийн нөхцөл байдал, хүний эрхийг зөрчсөн, байгалийн болон хүний хүчин зүйлээс үүдэлтэй гамшгийн үр дагавар буюу түүнээс зайлсхийхийн тулд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хилийг давалгүй, дотооддоо дүрвэх, гэр орноо орхих, эсвэл байнга оршин сууж буй газраа албадан орхих, эсвэл орхих үүрэг хүлээсэн хүмүүсийг хэлнэ.¹

Монгол Улсын хуулинд гадаадын иргэн, дамжин өнгөрөгч, түр ирэгч, хувийн хэргээр оршин суугч, албан хэргээр оршин суугч, харьяалалгүй хүн, цагаач зэрэг тодорхойлолтуудыг тусгасан байна.

Монгол Улсын Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 5.1.8-д “Цагаач гэж Монгол Улсын эрх бүхий байгууллагаас цагаачлан оршин суух зөвшөөрөл авсан гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг хэлнэ” гэж тодорхойлсон байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 18 дугаар зүйлийн 4 дүгээр заалтад: “Үзэл бодол, улс төрийн хийгээд шударга ёсны бусад үйл ажиллагааныхаа улмаас хавчигдан мөшгөгдсөн гадаадын иргэн, харьяалалгүй хүн үндэслэл бүхий хүсэлт гаргавал Монгол Улсад орогнох эрх олгож болно” хэмээн орогнол хүсэгчийн эрхийг баталгаажуулжээ.

Монгол Улс дүрвэгсдийн олон улсын гэрээ конвенцод нэгдэн ороогүй учраас үндэсний хууль тогтоомж, баримт бичгүүдэд дүрвэгсэдтэй холбоотой нэр томьёо, агуулгыг ашигладаггүй, зөвхөн судалгаа, шинжилгээний ажлын хүрээнд зарим эрдэмтэн, судлаачид бүтээлдээ хэрэглэж иржээ.

БХЭШХ-гээс эрхлэн гаргасан Цэргийн нэр томьёоны тайлбар тольд: “Дүрвэгсэд гэж иргэний дайн, дайн байлдаан, дотоодын хямрал, мөрдлөг хавчлага, улс төр, шашин шүтлэг, үндэс угсааны шалтгаанаар амь насанд нь аюул заналхийлсний улмаас өөрийн эх орноос дайжин гарсан иргэд” хэмээн тодорхойлжээ.

¹ Дотоодын шилжин явагчийн тодорхойлолт /татсан 2023.08.14/ <https://www.ohchr.org/en/special-procedures/sr-internally-displaced-persons/about-internally-displaced-persons>

Дүрвэгсдийн талаарх олон улсын эрх зүйн тодорхойлолтууд нь НҮБ-аас 1951 онд баталсан Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай конвенц, мөн конвенцын 1967 оны нэмэлт протокол, 1966 оны Дүрвэгсдэд олгох нөхцөлтэй холбогдсон зарчмууд, 1969 оны Африк тив дэх дүрвэгсдийн өвөрмөц асуудлыг зохицуулдаг Африкийн нэгдлийн байгууллагын конвенц, 1984 оны Латин Америкийн орнуудын Дүрвэгсдийн тухай конвенц буюу Картагенийн тунхаглал, 2018 оны Дүрвэгсдийн тухай дэлхийн гэрээнд тусгагджээ.

Дүрвэгсдийн олон улсын эрх зүйд тодорхойлсноор “дүрвэгсэд” гэж:

1. Арьс өнгө, шашин шүтлэг, иргэний харьяалал, нийгмийн тодорхой бүлгийн гишүүн, улс төрийн үзэл бодлын улмаас мөрдлөг хавчлагад өртөнө гэж бүрэн үндэслэлтэй болгоомжилж буйн учир харьяат орныхоо хамгаалалтыг эдэлж чадахгүй буюу дээрх болгоомжлолын улмаас эдлэхийг хүсэхгүй байгаа, эсвэл, иргэний харьяалалгүй бөгөөд тийм хэрэг явдлын улмаас өөрийн өмнө нь хэвийн оршин сууж байсан орноос гадна байгаа болон дээрх болгоомжлолын үүднээс буцаж чадахгүй буюу буцахыг хүсэхгүй байгаа хүнийг²;
2. Уугуул буюу харьяат оронд нь бүхэлдээ буюу аль нэг хэсэгт нь нийгмийн хэв журмыг ноцтой алдагдуулсан гадаадын түрэмгийлэл булаан эзлэлт, гаднын хүчирхийлэл буюу бусад хэрэг явдал тохиосны улмаас тэр орчноо арга буюу орхин гарсан аливаа хүн³;
3. Амь нас, аюулгүй байдал буюу эрх чөлөөнд нь түгээмэл хүчирхийлэл, гаднын түрэмгийлэл, дотоодын мөргөлдөөн, хүний эрхийг хавтгайруулан хөсөрдүүлсэн хүчирхийлэл буюу нийгмийн хэв журмыг ноцтой алдагдуулсан бусад нөхцөл байдлын улмаас эх орноо орхин гарсан хүмүүс⁴ зэргийг нэрлэж байна.

² Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай конвенц, 1951 он,

³ Африк тив дэх дүрвэгсдийн өвөрмөц асуудлыг зохицуулдаг Африкийн нэгдлийн байгууллагын конвенц, 1969 он

⁴ Латин Америкийн орнуудын дүрвэгсдийн конвенц ба Картагенийн тунхаглал, 1984 он

1.2. Дүрвэгсдийн олон улсын эрх зүй

Дүрвэгсдийн олон улсын эрх зүйн үндсийг 1951 оны Дүрвэгсдийн эрх зүйн байдлын конвенц, 1967 оны тус конвенцын нэмэлт протокол, 1966 оны Дүрвэгсдэд олгох нөхцөлтэй холбогдсон зарчмууд, 1969 оны Африкийн дүрвэгсдийн конвенц, 1984 оны Латин Америкийн орнуудын Дүрвэгсдийн конвенц буюу Картагенийн тунхаглал, 1997 оны Европын дүрвэгсэд, цагаачдын Дублины конвенц, түүнд суурилсан дүрмүүд, 2016 оны Дүрвэгсдийн тухай Нью-Йоркийн тунхаглал, 2018 оны Дүрвэгсдийн дэлхийн гэрээ зэрэг бүрдүүлж байна.

Мөн 1948 оны Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 1949 оны Женевийн конвенц, 1954 оны Харьяалалгүй хүмүүсийн эрх зүйн байдлын тухай конвенц, 1961 оны Харьяалалгүй байдлыг бууруулах тухай конвенц, 1989 оны Хүүхдийн эрхийн тухай конвенц зэрэгт дүрвэгсдийн эрх зүйн байдал тодорхой хэмжээгээр тусгагдсан байдаг.

Эдгээр гэрээ, конвенцоор улс төрийн үзэл бодлоороо гадуурхагдах эсвэл амьдарч байгаа, байнга оршин суудаг төрсөн нутагт нь амьдрах нөхцөлгүй боллоо хэмээн эх орноосоо дүрвэн гарсан хүмүүсийг хамгаалах олон улсын эрх зүйн асуудлыг зохицуулдаг.

Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай конвенцыг 1951 оны долоодугаар сард Женев хотод болсон олон улсын бага хурлаар баталж, түүнээс хойш 1967 онд Протоколын хэлбэрээр тус конвенцод нэмэлт өөрчлөлт оруулсан.

1967 оны 10 дугаар сарын 4-нд батлагдсан “1967 оны Протокол” нь газарзүйн болон цаг хугацааны хязгаарлалтыг арилгаж, конвенцыг бүх нийтээр дагаж мөрдөх, мөргөлдөөн, хавчлагаас зугтаж буй бүх хүмүүсийг хамгаалах зорилгоор даян дэлхийн конвенц болгон өргөжүүлсэн.

Дүрвэгсдийн тухай бүс нутгийн эрх зүйн баримт бичгүүд нь 1951 оны конвенцод тулгуурлаж, дүрвэгсдийг эх орноосоо дүрвэхэд хүргэдэг хэд хэдэн бодит нөхцөл байдлыг тусгасан байдаг. Жишээлбэл, 1969 оны Африкийн Дүрвэгсдийн тухай конвенцод

“гаднын түрэмгийлэл, эзлэн түрэмгийлэл, гадаадын ноёрхол эсвэл олон нийтийн дэг журмыг ноцтой зөрчиж буй үйл явдал”, 1984 оны Картагены тунхаглалд “нийтийн хүчирхийлэл, гадаадын түрэмгийлэл, дотоод зөрчил, хүний эрхийг их хэмжээгээр зөрчсөн эсвэл нийгмийн хэв журмыг ноцтой алдагдуулсан бусад нөхцөл” хэмээн эх орноосоо дүрвэхэд хүргэдэг хэд хэдэн бодит нөхцөл байдал, шалтгааныг ойролцоо утгаар тусгасан байдаг.

Дүрвэгсэд нь улс төрийн үзэл бодлоосоо болоод ялгаварлан гадуурхагдах, эрүүдэн шүүгдэх, ямар нэгэн гэмт хэрэгт мөрдөн шалгагдах бодитой үндэслэлийн улмаас гишүүн орнууд тэдгээрийг хүлээн авах, буцаахгүй байх, эрхийг хамгаалах үүргийг Дүрвэгсдийн 1952 оны үндсэн конвенц, бүс нутгийн эрх зүйн баримт бичгүүдээр хүлээдэг.

1951 онд батлагдсан Дүрвэгсдийн конвенцод 146 улс орон нэгдэж орсон ба Монгол Улс одоогоор тус конвенцод нэгдэн ороогүй байна. Дүрвэгсдийн конвенцыг хэрэгжүүлэх үндсэн үүрэгтэй НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн дээд комиссарын газар (ДДКГ) 1950 оны 12 дугаар сарын 14-ний өдөр байгуулагдсан.

Дүрвэгсдийн асуудлаар олон улсын эрх зүйн гол суурь гэрээ болох 1951 оны Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай конвенцын гол зарчим нь дүрвэгсдийг “нутаг буцаахгүй байх” явдал бөгөөд дараах эрхээр хангасан байдаг. Үүнд:

- Тодорхой, хатуу тогтоосон нөхцөлөөс бусад тохиолдолд хөөгдөхгүй байх эрх (32-р зүйл);
- Хэлэлцэн тохирогч улсын нутаг дэвсгэрт хууль бусаар нэвтэрсэн тохиолдолд шийтгэл хүлээхгүй байх эрх (31-р зүйл);
- Ялгаварлан гадуурхахгүй байх эрх (3 ба 5-р зүйл);
- Зохистой хөдөлмөрлөх эрх (17, 18, 19, 24-р зүйл);
- Орон сууц, газар, эд хөрөнгө, түүний дотор оюуны өмчийн эрх (13, 14, 21-р зүйл);
- Боловсрол эзэмших эрх (22-р зүйл);
- Шашин шүтэх эрх чөлөө (4-р зүйл);

- Шүүхэд хандах эрх (16-р зүйл);
- Нутаг дэвсгэр дотор чөлөөтэй зорчих эрх (26 дугаар зүйл);
- Иргэний үнэмлэх, аяллын бичиг баримт олгох эрх (12, 27, 28 дугаар зүйл);
- Нийгмийн хамгааллын эрх (23, 24-р зүйл).

Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн дээд комиссарын газар нь анх дэлхийн II дайны төгсгөлд Европт үүссэн дүрвэгсдийн асуудлыг 1951 оны Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай конвенцын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна. Энэ хугацаанд тус газар Африк дахь колоничлолын үр дүнд үүссэн дүрвэгсдийн асуудал, Ази, Латин Америк дахь цагаачлалын асуудал, Европ дахь дүрвэгсдийн хямралын асуудлыг шийдвэрлэхэд чухал үүрэг гүйцэтгэж, Нобелийн Энх тайвны шагналыг хоёр удаа хүртсэн.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас улс орнуудыг илүү хүмүүнлэг, зохицуулалттай хандлагын төлөө нэгтгэх зорилгоор дүрвэгсэд, цагаачдын асуудлыг шийдвэрлэх дээд түвшний уулзалт болох Дүрвэгсэд, цагаачдын дээд хэмжээний уулзалтыг 2016 оны есдүгээр сарын 19-нд зохион байгуулсан.

Дээд хэмжээний уулзалтаар дүрвэгсэд, цагаачлалын үндсэн шалтгаан, хүчин зүйл, дэлхийн хамтын ажиллагааны хэрэгцээг хэлэлцэж, дүрвэгсэд, цагаачдын асуудлаарх 2016 оны Нью-Йоркийн тунхаглалыг баталсан.

Нью-Йоркийн тунхаглалд үндэслэн 2018 оны 12 дугаар сарын 17-ний өдөр НҮБ-ын Ерөнхий Ассамблей дүрвэгсдийн асуудлыг тогтвортой шийдвэрлэхэд олон улсын хамтын ажиллагаагүйгээр үр дүнд хүрэх боломжгүй гэдгийг хүлээн зөвшөөрч, илүү урьдчилан сэргийлэх боломжтой, тэгш хариуцлага хүлээх тогтолцоо болох Дүрвэгсдийн тухай дэлхийн гэрээг баталсан.

Энэхүү гэрээ нь дүрвэгсэд болон түүнд өртсөн хүлээн авагч орнуудтай хамтын ажиллагаа, эв нэгдлийг бэхжүүлэх олон улсын хамтын нийгэмлэгийн улс төрийн хүсэл зориг, эрмэлзлийг илэрхийлдэг бөгөөд гол зорилго нь хүлээн авагч орнуудад үзүүлэх дарамтыг багасгах, дүрвэгсдийн бие даах чадварыг нэмэгдүүлэх, гуравдагч орны шийдлүүдийн хандалтыг өргөжүүлэх, эх орондоо

аюулгүй нэр төртэй буцаж ирэх нөхцөлийг дэмжих явдал юм.

1.3. Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн олон улсын байгууллагуудын чиг үүрэг



Дэлхийн II дайны дараа НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн дээд комиссарын газар (ДАЭДКГ)-ыг байгуулсан. Тус байгууллагын үйл ажиллагаа нь дүрвэгсдийн олон улсын эрх зүй, 1948 оны Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал, 1949 оны олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн Женевийн дөрвөн Конвенц зэрэг олон улсын болон бүс нутгийн бусад гэрээ конвенц тунхаглалд суурилдаг.

НҮБ-ын ДАЭДКГ-т дүрвэгсдийг хамгаалах болон тэдэнд асуудлаа шийдэх арга замыг олоход нь туслах бүрэн эрхийг нь НҮБ-аас олгосон бөгөөд тус газар нь төрийн бус, хүмүүнлэгийн агентлаг юм.

Зураг 1. Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай конвенцыг батлах үед оролцсон төлөөлөгч нар. 1951 он



Эх сурвалж: <https://www.unhcr.org/about-unhcr/who-we-are/1951-refugee-convention>

НҮБ-ын ДАЭДКГ 1950 онд Европын дүрвэгсдийн асуудлыг шийдэх зорилгоор гурван жилийн хугацаатай байгуулагдсан боловч

одоо 73 дахь жилдээ, жилийн 1 тэрбум ам.долларын төсөвтэй байгууллага болтлоо өргөжин тэлжээ. НҮБ-ын ДАЭДКГ нь бараг бүхэлд нь сайн дурын хандиваар үйл ажиллагаагаа явуулдаг НҮБ-ын цөөхөн агентлагийн нэг юм.

НҮБ-ын ДАЭДКГ дэлхийн дүрвэгсдийн нөхцөл байдалд хяналт тавих, дүрвэгсдэд эрх зүйн хамгаалалт үзүүлэхээс гадна дүрвэгсдэд шууд буюу түнш байгууллагаар дамжуулан материаллаг тусламж үзүүлдэг. Мөн бүрэн эрхийнхээ хүрээнд олон улсын гэрээ, конвенцоор дүрвэгсэд хэмээн тодорхойлогдсон хүмүүс, нийгмийн хэв журам ноцтой алдагдсанаас буюу мөргөлдөөнөөс зугтсан хүмүүс, дүрвэж яваад эх орондоо буцаж ирэгсэд, харьяалалгүй хүмүүс, дотооддоо шилжин явагсдын асуудлыг хянан шийдвэрлэдэг.

НҮБ-ын ДАЭДКГ-ын үндсэн чиг үүрэгт дүрвэгсдийн бүртгэл, статусыг тодорхойлох, бичиг баримт олгох, тусламж хуваарилах болон онцгой байдлын бэлэн байдал, хүмүүнлэгийн тусгай үйл ажиллагаа, өргөн хүрээний бүтээн байгуулалтын ажил багтдаг. Улмаар мөн дүрвэгсэд болон харьяалалгүй хүмүүст дипломат болон консулын хамгаалалт олгох, олон улсын түвшинд хууль ёсны төлөөлөх боломжгүй хүмүүсийн өмнөөс шууд хөндлөнгөөс оролцох, дүрвэгсдийг хамгаалах арга хэрэгслийг хэрэглэхэд хяналт тавих эрхтэй.

НҮБ-ын ДАЭДКГ нь 1951 оны конвенц, 1967 оны Протокол, 1969 оны Африкийн дүрвэгсдийн конвенц, 1984 оны Латин Америкийн Дүрвэгсдийн конвенц буюу Картагены тунхаглал, Европын Холбооны хууль тогтоомжийн хүрээнд гишүүн улсуудтай мэдээлэл солилцох, дүрвэгсдийн хууль эрх зүйг сурталчлах, олон нийтэд мэдээлэл өгөх, чадавхыг бэхжүүлэх, техникийн туслалцаа үзүүлэх, түншлэх, хууль тогтоомж, бодлого боловсруулагчдад туслах, үндэсний хууль тогтоомж, бодлогын санаачилгад тайлбар өгөх, дүрвэгсдийн хууль эрх зүйн оролцоог хангах, олон улсын хууль тогтоомжид нийцсэн шийдвэр гаргахад хамтран ажилладаг.

Дүрвэгсэд нь НҮБ-ын ДАЭДКГ-ын үндсэн чиг үүргийн нэг хэсэг бөгөөд дүрвэгсэд нь олон улсын болон бүс нутгийн дүрвэгсдийн гэрээ конвенц, дээд комиссарын бүрэн эрх, үндэсний хууль тогтоомжид заасан тодорхойлолтын дагуу зохих шалгуурыг хангасан бүх хүн юм.

Орогнол хүсэгчид нь НҮБ-ын ДАЭДКГ-ын бүрэн эрхэд хамаарах бөгөөд тэдгээр нь дүрвэгчийн статус буюу олон улсын нэмэлт хамгаалалтын статус авахыг хүсэж байгаа, дүрвэгчийн статус нь хараахан тогтоогдоогүй байгаа хүмүүсийг хэлнэ. Орогнол хүссэн хүн бүр эцсийн дүндээ дүрвэгч гэж хүлээн зөвшөөрөгдөхгүй. Гэсэн хэдий ч, орогнол хүсэгч нь статусыг нь тодорхойлогдох хүртэл буцаан илгээгдэхгүй байх эрхтэй.

Эргэн ирсэн хүмүүс /Returnees/ мөн НҮБ-ын ДАЭДКГ-ын үндсэн чиг үүрэгт багтдаг бөгөөд тэдгээр нь дүрвэж яваад эх орондоо зохион байгуулалттайгаар буцаж ирсэн дүрвэгсэд бөгөөд НҮБ-ын ДАЭДКГ тэдгээрийг буцаж ирсний дараах асуудалд хяналт тавьж, дахин нийгэмшүүлэхэд туслалцаа үзүүлдэг.

Харьяалалгүй хүмүүсийг төлөөлөх үйл ажиллагаа нь НҮБ-ын ДАЭДКГ-ын дүрмээр олгогдсон чиг үүргийн нэг хэсэг бөгөөд эдгээрт харьяалалгүй хүмүүсийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, бууруулах, харьяалалгүй хүмүүсийг хамгаалах зэрэг үйл ажиллагаанууд багтдаг.

НҮБ-ын ДАЭДКГ нь дотоод дүрвэгсдийн талаар ерөнхий болон онцгой бүрэн эрхгүй ч тодорхой нөхцөл байдалд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга эсвэл НҮБ-ын эрх бүхий үндсэн байгууллагаас гаргасан тусгай хүсэлт, зөвшөөрлийн дагуу дүрвэгсдийг хамгаалах, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх үйл ажиллагаа явуулах боломжтой байдаг.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас санал болгосноор Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн дээд комиссарыг таван жилийн хугацаагаар томилдог. Дээд комиссар Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн гүйцэтгэх хороогоор уламжлан Ерөнхий Ассамблейд ажлаа тайлагнадаг.

Тус хорооны чиг үүрэг нь Дээд комиссарын тусламжийн хөтөлбөрийг батлах, Дээд комиссарт олон улсын онцгой хамгаалалтын нөхцөлд дүрмийн чиг үүргээ гүйцэтгэхэд нь зөвлөгөө өгөх, дүрвэгсдийн, агентлагийн, санхүүгийн болон захиргааны үйл ажиллагааг бүх талаар нь нягтлан хянаж дэмжлэг үзүүлэхэд оршино.

Дээд комиссарын үндсэн үүрэг нь дүрвэгсдийг олон улсын хамгаалалтаар хангах, дүрвэгсдийг сайн дураараа эх оронд нь буцаах, эсвэл дүрвэгсдийг эх оронд нь нутагшуулахад дэмжлэг үзүүлэх замаар дүрвэгсдийн асуудлыг шийдвэрлэх явдал юм. Дээд комиссарын үүрэг нь хүмүүнлэгийн болон нийгмийн шинж чанартай бөгөөд түүнд дараах чиг үүрэг хамаарна. Үүнд:

1. Дүрвэгсдийг хамгаалах олон улсын конвенц байгуулах, соёрхон батлах, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих, нэмэлт, өөрчлөлт оруулах талаар санал гаргах;
2. Дүрвэгсдийн нөхцөл байдлыг хөнгөвчлөх, хамгаалах шаардлагатай дүрвэгсдийн тоог бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
3. Дүрвэгсдийг сайн дураараа эх оронд нь буцаах, эсхүл шинэ улс оронд “уусгах” үйл ажиллагаа, хүчин чармайлтыг дэмжих;
4. Дүрвэгсдийг янз бүрийн улсын нутаг дэвсгэрт нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
5. Дүрвэгсдийн эд хөрөнгийг шилжүүлэх ажлыг хөнгөвчлөх; өөрийн нутаг дэвсгэрт байгаа дүрвэгсдийн тоо, тэдний нөхцөл байдлын талаар, түүнчлэн холбогдох хууль тогтоомжийн талаар Засгийн газраас мэдээлэл авах;
6. Засгийн газартай болон Засгийн газар хоорондын байгууллагуудтай нягт харилцаатай байх;
7. Дүрвэгсдийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор хувийн болон төрийн бус байгууллагуудтай холбоо тогтоох;
8. Дүрвэгсдийн асуудлаар хувийн хэвшлийн байгууллагуудын хүчин чармайлтын зохицуулалтыг хөнгөвчлөх.

Дээд комиссар нь Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн гүйцэтгэх хороогоор уламжлан Ерөнхий Ассамблейд ажлаа тайлагнадаг.

II ДҮРВЭГСДИЙН АСУУДЛААРХ ОЛОН УЛСЫН ТҮРШЛАГА, СУРГАМЖ

2.1. Дүрвэгсдийн асуудлаарх олон улс, бүс нутгийн нөхцөл байдал



НҮБ-ын ДАЭДКГ-аас дэлхий даяар орон гэрээ орхихоос аргагүй байдалд орсон иргэдийн тоо түүхэнд байгаагүй өндөр хэмжээнд буюу 100 саяд хүрснийг жил бүр гаргадаг “Global Trends 2022”⁵ тайланг зарлах үеэрээ мэдэгдсэн.

Дэлхий дахинд өнөөдрийн байдлаар 110 сая орчим дүрвэгсэд улс төр, эдийн засгийн шалтгаанаар дүрвээд байна. Дайн, өлсгөлөн, иргэний дайн, өвчин тахал, хувьсгал, шашны мөргөлдөөн, зэвсэгт мөргөлдөөн, төрийн эргэлт, ган, зуд, газар хөдлөл, үер

зэрэг нь иргэдийг дүрвэлтэд хүргэх гол шалтгаан болж байна.

⁵ <https://www.unhcr.org/global-trends-report-2022> (татсан: 2023.08.15)

Дэлхий дахинаа үүсээд байгаа хямрал, сөргөлдөөний хамгийн том хохирогчид нь энгийн иргэд дүрвэгсэд байсаар байна. Сири, Афганистан, Украин зэрэг улс оронд өрнөж буй зэвсэгт мөргөлдөөний улмаас энгийн иргэд хамгийн ихээр дүрвэж байна. 2022 онд зөрчил, мөргөлдөөн, хүчирхийлэл, гэмт хэрэг зэрэг хүчин зүйлийн улмаас төрөлх хот, нутаг орноо орхин явж буй иргэдийн тоо дэлхий даяар 19 саяар нэмэгджээ.

Украины зэвсэгт мөргөлдөөн гэхэд дэлхийн II дайнаас хойш хамгийн богино хугацаанд, хамгийн олон хүнийг дүрвэхэд хүргэсэн гэж НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн дээд комиссарын газрын тайланд дурдсан байна.

2022 оны байдлаар хамгийн олон дүрвэгсэдтэй улс орон:

- Украин - 14 сая;
- Сири - 6.8 сая;
- Палестин - 5.8 сая ;
- Афганистан - 2.6 сая дүрвэгсэд байна.

НҮБ-ын ДАЭДКГ-ын тайланд өнгөрсөн 10 жилийн хугацаанд дүрвэгсдийн хямрал дэлхийн хэмжээнд нэг дахин нэмэгдсэн, 100-гаас илүү сая хүн орон гэрээ хүчээр орхиход хүрсэн. Энэ нь дэлхийн хүн амын 1.2 хувь болох бөгөөд 97 сая хүнтэй Вьетнам, 84 сая хүнтэй Турк, 83 сая хүнтэй Герман улсын хүн амаас олон хүн орон гэрээсээ хүчинд автан дүрвэн амьдарч байна. Тэдгээрийн 32.5 сая нь дүрвэгсдэд тооцогдох бөгөөд нийт дүрвэгсдийн 76 хувь нь Украин, Сири зэрэг зургаан улсаас дүрвэгсэд байна.⁶

Хамгийн олон дүрвэгсэд хүлээн авагч улс нь:

- Турк – 3.7 сая;
- Иордан – 3 сая;
- Колумб – 1.7 сая;
- Уганда -1.5 сая;
- Пакистан - 1.4 сая дүрвэгсдийг хүлээн авсан байна.

⁶ The 10 largest refugee crises to know in 2023. <https://concernusa.org/news/largest-refugee-crises/#:~:text=In%20the%20past%20decade%2C%20the,are%20over%2032.5%20million%20refugees> (татсан: 2023.08.15)

Эдгээр улс нь дийлэнхдээ бага болон дунд орлоготой байгаагийн зэрэгцээ дүрвэгсдийн хамгийн ойр байрлалтай улс учраас тэдний хөлд хүссэн, хүсээгүй нэрвэгдэх нөхцөл байдлыг бий болгож байна.

Суданд дотоодын зөрчил тэмцэл 2023 оны дөрөвдүгээр сард болсноос 1.4 сая хүн гэр орноо орхин хил залгаа Ливи, Чад, Төв Африкийн Бүгд Найрамдах Улс, Өмнөд Судан, Этиоп руу дүрвэсэн бол өмнө нь тэдгээр улсад тогтворгүй байдал үүссэний улмаас сая илүү дүрвэгсдийг нь Судан улс өөрөө хүлээн авч байсан байдаг.

Соёл нийгэм, улс төрийн шалтгаан, эдийн засгийн дотоод хэрэгцээ болон зарим улсын улс төрийн шийдлийн үүднээс дүрвэгсдийг олон тоогоор хүлээн авах тохиолдлууд байдаг. Тухайлбал, Герман улс гэхэд хөдөлмөрийн насны хүн амын тоо буурч байгаатай холбоотойгоор 2022 онд 1.3 сая дүрвэгсдийг хүлээн авсан бөгөөд тэдгээрийн сая гаруй нь Украины дүрвэгсэд байна. Герман улс хүлээн авсан дүрвэгсдийг өөрийн улсдаа суурьшуулах, нийгэмшүүлэх ажиллагааг системтэйгээр авч хэрэгжүүлж байна.

Афганистанд Талибаны дэглэм засгийн эрхийг авснаас хойш АНУ-д богино хугацаанд 90 мянган дүрвэгчийг хүлээн авсан нь тухайн үед АНУ-тай хамтран ажиллаж байсан афганчуудыг хүлээн авсан улс төрийн шийдэл байсан бөгөөд тус улсын Конгресс дээр тэдгээрийн эрх зүйн байдлыг тогтоох төсөл хэлэлцэгдэж байна.

Олон тооны дүрвэгсэд гэнэт орж ирсэн ачааллыг тухайн улс сааруулахын тулд дийлэнхдээ дүрвэгсдийг хуаранд байрлуулах нөхцөл байдал бий болдог байна. Тухайлбал, Бангладешийн Кох базаар (Cox's bazar) дахь Мьянмараас дүрвэсэн Рохингя лалын дүрвэгсдийг байрлуулж буй Кутупалонг (Kutupalong) дүрвэгсдийн хуаран 1 сая дүрвэгсэдтэй дэлхийн хамгийн том дүрвэгсдийн хуаран болж байна. Кени улс дахь Дадааб дүрвэгсдийн хуаранд 220 мянга, Какумад 185 мянга, Иордани дахь Заатари хуаранд 76 мянган дүрвэгсэд байна.

Дүрвэгсэд нутгаа хүчээр орхин явахад хүрч байгаа олон шалтгаан байх бөгөөд хамгийн гол шалтгаанд:

1. Шашны, үндэсний, нийгмийн, яс үндсээр, улс төрийн үүднээс хавчилга мөрдлөг;
2. Дайн;

3. Хүйсийн чиглэл;
4. Өлсгөлөн;
5. Цаг уурын өөрчлөлт орж байна.

Тухайлбал, шашны улмаас үүсэж буй дүрвэгсдийн жишээгээр Мьянмараас дайжиж буй лалын шашинтнууд, Төв Африкийн бүгд найрамдах улс дахь Христүүд, Пакистан дахь Хиндү шашинтнуудыг нэрлэж болно. Дайны улмаас бий болж буй дүрвэгсдийн жишээ Афганистан, Ирак, Сири, Украин болж байгаа юм.

Цаашид өлсгөлөн, цаг уурын өөрчлөлт зэргээс бий болох дүрвэгсдийн тоо нэмэгдэх хандлагатай байна. НҮБ-ын ДАЭДКГ-ын дүгнэж байгаагаар цаг уурын болон бусад хямралын улмаас 2050 он гэхэд дэлхийн хэмжээнд 1 тэрбум хүн төрсөн орон гэрээсээ өөр газар шилжих нөхцөл байдал үүсэхээр байна.

Дүрвэгсдийн асуудал олон учир шалтгаантай, зарим тохиолдолд олон шалтгаан холимог давхардсан байдлаар нөлөөлдөг, урьдчилан төсөөлөх боломжгүй асуудал учраас дүрвэгсдийн асуудалд бүрэн бэлэн байдаг улс орон гэж дэлхийд байдаггүй байна. Сирийн иргэний дайны улмаас 4 сая гаруй дүрвэгсдийн хөлд нэрвэгдсэн Европ, Украины дайны улмаас олон сая хүнээ хүчээр нүүлгэн шилжүүлэх болсон Украин, дотоодын зөрчил тэмцлийн улмаас олон сая хүнээ гадагш гаргасан Судан зэрэг улсын жишээнээс үүнийг харах боломжтой.

2.2. Олон улсын болон үндэсний хэмжээнд дүрвэгсдийг хамгаалах асуудал

Дүрвэгсдийг хамгаалах асуудалд тухайн улс нутаг дэвсгэртээ нэвтрүүлэх, аюулгүй байдлыг хангах, дүрвэгсэд болон орогнол хүсэгчдийг орогнолын тогтолцооны хүрээнд хүлээн авах, статусыг тодорхойлох, эрх зүйн байдлыг хүлээн зөвшөөрөх, хүний эрхийг хүндэтгэх зэрэг багтаж байна.

Дүрвэгсдийг хамгаалах гол зарчим нь эх оронд нь буцаахгүй байх, дүрвэгсдийн эрх, нэр төрийг хүндэтгэх, ялгаварлан гадуурхахгүй байх явдал юм.

Дүрвэгсдийн 1951 оны конвенцод гарын үсэг зурсан улс орнууд дүрвэгсдийг нутаг дэвсгэртээ хамгаалж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартын дагуу тэдэнтэй харилцах үүрэгтэй.

Дүрвэгсдийг хүлээн авагч Засгийн газрын ерөнхий удирдлага дор түншлэлд суурилсан, хүртээмжтэй зохицуулалт нь дүрвэгсдэд яаралтай тусламж үзүүлэх үр дүнтэй ажиллагааны урьдчилсан нөхцөл болдог. Үр дүнтэй зохицуулалт, манлайлал, улс төрийн хүсэл эрмэлзэл нь дүрвэгсдэд хамгаалалт, тусламж үзүүлэхэд шууд нөлөөлдөг.

Дүрвэгсдийг хүлээн авч буй улс орнууд их хэмжээний хүн амын шилжилт хөдөлгөөнд дарагдах, үндэсний чадавх нь хүрэлцэхгүй байх зэрэг олон бэрхшээл гардаг ч тэднийг буцаахгүй байх, орогнох эрхийг хүндэтгэх, хүний эрхийн үндсэн зарчмуудад нийцсэн хууль эрх зүйн орчин, хүлээн авах зохицуулалт, төлөвлөлт, менежментийг бий болгосон байх шаардлагатай.

Дүрвэгсдийн ачаалал хуваалцах олон улсын хамтын ажиллагаа нь хүлээн авагч улсад туслах, аюул эрсдэлийг бууруулах, хамгаалалтыг сайжруулах, орогногчийн иргэний болон хүмүүнлэгийн шинж чанарыг хангах арга хэмжээ авах явдал юм.

Дүрвэгсдийг олон нийтийн газар эсвэл задгай газар хүлээн авах нь ердийн үзэгдэл бөгөөд цагдан хорих шаардлагатай хаалттай байгууламжийг зөвхөн эцсийн арга хэмжээ болгон ашиглах ёстой. Орогнол хүсэгчдийг саатуулж байгаа тохиолдол нь үндэслэлтэй эсэх, хууль ёсны зорилготой байх, анхан шатны болон цаг хугацааны явцад хувь хүн тус бүрээр тодорхойлох үндсэн дээр явагдах ёстой.

Дүрвэгсдийн асуудлыг шийдвэрлэх үндэсний хууль тогтоомж, бодлогыг боловсруулахдаа дараах зүйлийг тусгасан байх шаардлагатай. Үүнд:

- Хамгаалалт хүсэж буй хүмүүсийг бүртгэх, хэрэгцээг тодорхойлох, үйлчилгээ үзүүлэх, аюулгүй байдлыг хангах, эрүүл мэндийн тусламж үзүүлэх, эмчлэх боломжоор хангах;
- Шилжилт хөдөлгөөний эрх чөлөө, цагдан хорих болон хорихоос өөр хувилбарыг боловсруулж, хэрэгжүүлэх;
- Онцгой байдлын үед хариу арга хэмжээ авах;
- Өөрийгөө тэжээх чадваргүй орогнол хүсэгчдэд үзүүлэх төрийн тусламжийн цар хүрээг тодорхойлох зэрэг багтана.

Дүрвэгсдийн 1951 оны конвенц, 1967 оны Протоколд орогнол хүсэгчдийг хүлээн авах стандартыг заагаагүй боловч ялгаварлан гадуурхахгүй байх, шашин шүтэх эрх чөлөө, шүүхэд хандах, боловсрол эзэмших, иргэний үнэмлэх авах, хоол хүнс, орон байр, эмнэлгийн тусламж үйлчилгээ авах зэрэг хүний эрхийн наад захын асуудлууд тусгагдсан байдгийг мөн үндэсний хууль тогтоомжид харгалзан үзэх ёстой.

Дүрвэгсдийн олон улсын гэрээ конвенцод нэгдсэн улс орнууд үндэсний хууль тогтоомжоор тухайн улсын нутаг дэвсгэр дэх дүрвэгсэд, орогнол хүсэгч, цагаач зэрэг гадаадын иргэдийн эрх зүйн байдлыг тодорхойлсон байдаг.

Үндэсний хууль тогтоомжид тухайн улс орогнол хүсэгч, дүрвэгсдэд орогнох эрх олгох, албадан гаргахаас урьдчилан сэргийлэх, ялгаварлан гадуурхахгүй байх, хувийн амьдралын талаарх мэдээллийн нууцлалыг хадгалах, гэр бүлийг нэгтгэхэд дэмжлэг үзүүлэх, юуны өмнө хүүхэд, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах талаар тусгадаг. Мөн тэдэнд байр, хоол хүнсээр хангагдах, хөдөлмөрлөх, аж ахуй эрхлэх, эмнэлгийн тусламж авах, орчуулагчийн үйлчилгээ авах, консулын газар, шүүхэд хандах, давж заалдах, эх орондоо сайн дураараа буцах буюу аль нэг гуравдагч улс руу шилжих, санхүүгийн төлбөр тооцоо хийх, дүрвэгсдийн гэрчилгээ, аяллын бичиг баримт авах эрхийг хуулиар олгодог байна.

Хэрэв дүрвэгсэд нь санаатайгаар худал мэдээлэл өгсөн, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн, терроризм зэрэг олон улсын гэмт хэрэгт холбогдсон, тухайн улсын хуулийг зөрчсөн бол дүрвэгчийн статус олгохгүй байх үндэслэл болдог.

Хууль тогтоомжид орогнол хүсэгч, дүрвэгч хүүхдийн эрхийг нэн тэргүүнд хамгаалах, боловсрол эзэмших, хорих байрнаас гадуур байлгах, цагдан хорихгүй байх, эцэг эх, асран хамгаалагчтай нь хамт байлгах, хараа хяналтгүй, хамгаалалтгүй хүүхдүүдэд хараат бус, мэргэшсэн асран хамгаалагч, хуулийн зөвлөхийг яаралтай томилох хэрэгтэй. Олон улсын туршлагад ерөнхийдөө жирэмсэн болон хөхүүл дүрвэгч эхчүүдийг саатуулах, хорихыг хориглож, бэлгийн болон жендэрт суурилсан хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах хамгаалалт зэрэг тэдний онцлог хэрэгцээг харгалзан үзэх ёстой. Орогнол хүсэгч эмэгтэйчүүдийг цагдан хорьсон тохиолдолд тэдний

эрүүл ахуйн тусгай хэрэгцээг хангах барилга байгууламж, материал хэрэгсэл, харуул, харгалзагч эмэгтэйн оролцоог хангах хэрэгтэй. Хоригдсон эмэгтэйчүүдтэй ажиллахаар томилогдсон бүх ажилтнууд эмэгтэйчүүдийн жендэрийн онцлогтой холбоотой хэрэгцээ, хүний эрхийн талаар сургалтад хамрагдсан байх ёстой. Эмэгтэйчүүд болон гэр бүлд зориулсан тусдаа хорих байр байхгүй тохиолдолд цагдан хорихоос өөр хувилбаруудыг эрэлхийлэх хэрэгтэй.

Зураг 2.БНТУ-д байрлаж буй дүрвэгсдийн хуаран



Эх сурвалж: <https://fluxtrends.com/refugees-cities/>

“Дэлхийн дүрвэгсдийн өдөр”-ийг жил бүрийн зургаадугаар сарын 20-нд тэмдэглэх тогтоолыг НҮБ-ын Ерөнхий Ассамблей 2000 оны 12 дугаар сард баталж, албан ёсоор анх удаагаа 2001 онд тэмдэглэж эхэлсэн нь 1951 оны Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай конвенцын 50 жилийн ойтой давхцаж байгаа юм.

Дэлхийн дүрвэгсдийн өдрөөр дүрвэгсдийн эрх, тэдний хэрэгцээ, хүсэл мөрөөдлийг бадраах, тэдэнд туслахаар бусдыг дайчлах, дүрвэгсдийн хамгаалалтыг сайжруулах үйл ажиллагааг дүрвэгсэд өөрсдөө болон дүрвэж гарсан, хүлээн авагч орны Засгийн газрын албан тушаалтнууд, хувийн хэвшлийнхэн, ТББ-ууд, олны танил эрхмүүд, олон нийтийн байгууллагын идэвхтнүүд, сургуулийн хүүхдүүд болон бусад энгийн иргэд, олон нийт зохион байгуулан явуулдаг.

2.3. Дүрвэгсдийн урсгалын сөрөг нөлөө

Хэдийгээр дүрвэгсэдтэй холбоотой аюулгүй байдлын эрсдэлийг дэгсдүүлэх хандлага байдаг боловч түүхээс харахад дүрвэгсдийн хөдөлгөөн нь зөвхөн хүмүүнлэгийн асуудлаар хязгаарлагддаггүй. Улс төр, аюулгүй байдлын маш хүчтэй эрсдэлийг улс орны дотоодын аюулгүй байдалд бий болгож байдаг. Сүүлийн жилүүдэд бий болж байгаа болон өмнө байсан дүрвэгсдийг хүлээн авагч улсын Засгийн газрын зүгээс дотоодын хэв журам, аюулгүй байдалд нь учрах аюул, эрсдэл хэмээн үзэх хандлага нэмэгдэж байна.⁷

Дүрвэгсэдтэй холбоотойгоор хүчирхийлэл, гэмт хэрэг, зөрчил, ядуурал, ажилгүйдэл зэрэг нийгмийн сөрөг үзэгдэл, хор хохирол бий болж байна. Түүнчлэн дүрвэгсдийн тоо нэмэгдэхийн хэрээр тэдгээрийг хүлээн авагч улсын эдийн засгийн хөгжлийг доош татах, үндэсний эв нэгдэл, дотоодын дэг журмын асуудалд ихээхэн сөрөг нөлөө авчрах болж байна. Тухайлбал, Франц болон АНУ-д гарч буй нийгмийн эв нэгдэлд хортой эсэргүүцэл, тэмцлийг дүрвэж болон цагаачилж ирсэн үндэстэн, ястан гаргаж буй нь дотоодын аюулгүй байдалд хамгийн том аюул учруулах нөхцөлүүдийг бий болгож байна.

Дүрвэгсдийг хүлээн авч буй улсуудын хувьд харахад бага орлоготой улсууд дэлхийн дотоодын нийт бүтээгдэхүүний 0.5 хувь, хүн амын 9 хувийг эзэлж байгаа боловч нийт дүрвэгсдийн 18 хувийг хүлээн авсан байна.

Гэтэл дунд болон өндөр орлоготой улсууд дэлхийн дотоодын нийт бүтээгдэхүүний 99.5 хувь, хүн амын 91 хувийг эзэлж байгаа боловч нийт дүрвэгсдийн 82 хувийг хүлээн авч байгаа нь тэнцвэртэй бус байдал юм. Эндээс дүгнэлт хийхэд ядуу бөгөөд хөгжил багатай орнууд дүрвэгсдийг хязгаарлах, хүлээн авахгүй байх, шийдэл олох боломжгүй учраас хүчээр буюу өөрсдийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлыг муутган байж хүлээн авах нөхцөл байдалд хүрч байгаа нь харагдаж байна.

⁷ Gil Loescher. “Blaming the Victim: Refugees and Global security”. <https://journals.sagepub.com/doi/pdf/10.2968/058006011#:~:text=While%20the%20security%20threat%20associated,domestic%20and%20in%2D%20ternational%20order>. (Татсан: 2023.08.15)

Дүрвэгсдийн тухайн улсад байх хугацаанаас шалтгаалан тухайн улсад учруулах дарамт, ачаалал өөр өөр байна. Тухайлбал, Афганистаны олон арван жилийн дүрвэгсдийн асуудлаар Пакистан, Иран зэрэг улс хүссэн, хүсээгүй ч ачааллыг нуруундаа үүрч, яс үндэс, хэл соёл ижил дүрвэгсдийг нийгэмдээ шингээх нь улс орны эдийн засагт хүндрэл учруулах гол нөхцөл болж байна. Харин Польш зэрэг улсын хувьд Украиныг дайнд дэмжиж буй Европын Холбооны хамгийн гол орны хувьд цэрэг, хүмүүнлэгийн тусламж хамгийн идэвхтэй үзүүлж, хамгийн их Украины дүрвэгсдийг хүлээн авч байгаа нь улс төрийн учир шалтгаантай гэж үзэж байна.

Улс орнууд өөрийн нөхцөл байдлын улмаас Дүрвэгсдийн асуудлаарх гэрээ, конвенцод элсэх асуудалд хойрго хандаж байгаагийн улмаас НҮБ-аас дүрвэгсдийн асуудлыг шийдвэрлэхэд бүх нийтийн оролцоог хангах зорилгоор НҮБ 2018 онд дэлхийн 193 гишүүн хүлээн зөвшөөрсөн Дүрвэгсдийн асуудлаарх дэлхийн гэрээ баримт бичгийг гаргасан. Дэлхийн гэрээгээр дүрвэгсдийг хүлээн авч бус улсад үзүүлж буй дарамт, ачааллыг хөнгөвчлөх, дүрвэгсдийг бие даасан байх асуудалд дэмжлэг үзүүлэх, дүрвэгсдийг гуравдагч улсад гаргах, өөр бусад нэмэлт арга хэмжээ бий болгох, тэдгээрийг сайн дураараа нутагтаа буцах нөхцөлийг бий болгох гэсэн зарчмуудыг тусгасан.

Энэхүү гэрээний хүрээнд Украины дүрвэгсдийн талаар түр хугацааны хамгаалалтын заавар гаргаж, тэдний орон сууц, эрүүл мэнд, боловсрол, ажил эрхлэх асуудлыг шийдвэрлэж байна.

III ДҮРВЭГСЭД БА МОНГОЛ УЛС

3.1. Дүрвэгсдийн асуудлаарх Монгол Улсын эрх зүйн орчин, туршлага сургамж

Монгол Улс 1951 оны Дүрвэгсдийн конвенцод болон түүний 1967 оны Протоколд нэгдээгүй ч нэгдэх талаар Засгийн газар хэд хэдэн удаа хүчин чармайлт гаргаж байсан. Тухайлбал, 2009 онд Дүрвэгсдийн конвенцод нэгдэн орох талаар Засгийн газрын хуралдаан, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр хэлэлцүүлсэн байдаг.

1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуулийн 18 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт: “Итгэл үнэмшил, улс төрийн болон бусад үйл ажиллагааны улмаас хэлмэгдсэн гадаадын иргэн, харьяалалгүй хүн, мөн шударга ёсны төлөө явж буй хүмүүсийн үндэслэл бүхий хүсэлтийн үндсэн дээр Монгол Улсаас орогнол олгож болно” хэмээн заасан нь гадаад улсын дүрвэгсдийн Монгол Улсад орогнох эрхийг баталгаажуулсан эрх зүйн зохицуулалт юм.

Монгол Улс дүрвэгсдийн эрх зүйн байдлын гол зарчим болох эх оронд нь “буцаан шилжүүлэхгүй байх” зарчмыг хүндэтгэн үзэж, дүрвэгсдийн эрх зүйн байдлын талаарх амлалтаа үргэлжлүүлэн биелүүлсээр ирсэн. Тухайлбал, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.3-д гадаадын иргэнд улс төрийн орогнол хүсэх эрхийг нь үндэсний хууль тогтоомжоор давхар баталгаажуулсан явдал юм.

Монгол Улсын 1990 онд нэгдэн орсон Хүүхдийн эрхийн конвенцын 22 дугаар зүйлд: “Оролцогч улсууд эцэг эх нь буюу

өөр бусад хүн дагалдсан эсэхийг үл харгалзан дүрвэгчийн эрх олж авахыг хүссэн буюу дагаж мөрдөж байгаа олон улсын буюу дотоодын хууль, журмын дагуу дүрвэгч хэмээн тооцогдох хүүхдэд энэхүү Конвенц болон тухайн орны нэгдэн орсон хүний эрхийн буюу хүмүүнлэгийн олон улсын бусад баримт бичигт заасан эрхээ эдлэхэд зохих хамгаалалт, хүмүүнлэгийн туслалцаа үзүүлэх шаардлагатай арга хэмжээг авна” хэмээн заасан нь Монгол Улс Дүрвэгсдийн конвенцод нэгдээгүй ч хүний эрх, хүмүүнлэгийн бусад нэгдэн орсон олон улсын эрх зүйгээр дүрвэгсдийг хамгаалах зарим үүрэг хүлээж байна.

Мөн олон улсын орогнол хүсэгч, дүрвэгсдийн хамгаалалтыг хангах зорилгоор Монгол Улс НҮБ-ын ДАЭДКГ-тай 2007 онд харилцан ойлголцох Санамж бичиг байгуулан дүрвэгсдийн бичиг баримт бүрдүүлэх, оршин суух зөвшөөрөл олгох, дүрвэгсдийн статусыг тодорхойлох, орогнол хүсэгчид болон дүрвэгсдэд тусламж үзүүлэх, тэдэнд зориулсан удаан хугацааны тогтвортой шийдлүүдийг тодорхойлох талаар НҮБ-ын холбогдох агентлаг, гадаад улсын Засгийн газар, талуудтай хамтран ажиллаж, дүрвэгсдийн асуудлаар олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлж байна.

Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа орогнол хүсэгч, дүрвэгсдийг хамгаалах үүднээс НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн дээд комиссарын газраас Монгол Улсыг дүрвэгсдийн гэрээ конвенцод элсүүлэх, үндэсний хууль тогтоомжид зохицуулалт хийх талаар эрх зүйн дэмжлэг үзүүлсээр байна.

Монгол Улс Иргэний болон улс төрийн эрхийн тухай болон Хүүхдийн эрхийн тухай конвенцод нэгдэн орж, үндэсний хууль тогтоомжид: “Монгол Улсын нутаг дэвсгэрт төрсөн хүүхэд нь Монгол Улсын харьяат байх”-аар хуульчилсан нь дүрвэгсдийн хүүхдүүд харьяалалгүй болохоос урьдчилан сэргийлсэн, хүүхэд бүрийн иргэншил авах эрхийг хангасан чухал зохицуулалт юм.

Монгол Улсад дүрвэгсдийн тухай тусгайлсан хууль байхгүй тул НҮБ-ын ДАЭДКГ нь Монгол Улсад орогнол хүссэн хүмүүсийн дүрвэгсдийн статусыг тодорхойлох, бүртгэх, тогтоох асуудлыг үндсэндээ хариуцаж, дүрвэгсэд болон орогнол хүсэгчдэд тодорхой хэрэгцээний амьдрах байраар хангахад туслалцаа үзүүлж байна.

1921 онд Монгол Улсын нутаг дэвсгэрт орж ирсэн Барон

Унгерны зэвсэгт бүлэглэл, Монгол Улсын нутаг дэвсгэрээс улс төрийн шалтгаанаар дүрвэсэн монгол иргэд (1930-1945 оны хэлмэгдлийн үе), баруун хил дээрх их нүүдэл зэрэг нь дотоод гадаадын дүрвэгсэдтэй холбоотой түүхэн сургамж юм.

ОХУ, Украины хооронд 2022 оны хоёрдугаар сарын 24-нөөс хойш одоог хүртэл үргэлжилж буй зэвсэгт мөргөлдөөний асуудал нь хөрш улс орнуудад аюулгүй байдлаа хэрхэн хангах хүрээнд томоохон сорилтыг бий болгоод байгаа бөгөөд ялангуяа дайнаас дүрвэгсдийн асуудал нэн тэргүүний тулгамдсан асуудлын нэг болоод байна.

Зураг 3. Орос, Украины дайны улмаас эх орноосоо дүрвэн яваа Украины иргэд



Эх сурвалж: <https://www.unhcr.org/neu/75799-unhcr-mobilizing-to-aid-forcibly-displaced-in-ukraine-and-neighbouring-countries.html>

Дээр дурдсан олон улс, бүс нутагт өрнөж буй нөхцөл байдлууд нь дэлхийн аль ч улс оронд дүрвэгсдийн асуудлыг орхигдуулж болохгүйг харуулж байна. Олон улс, бүс нутаг, хил залгаа улсад янз бүрийн нөхцөл байдал үүссэн тохиолдолд Монгол Улсад ирээдүйд дүрвэгсэд бөөнөөрөө орж ирэх магадлал байсаар байна.

Сүүлийн үед дэлхийн улс орнуудад болж буй цаг уурын өөрчлөлтөөс үүдэлтэйгээр болж буй үер, гал түймэр, ган, зуд зэрэг

аюулт үзэгдлийн улмаас аргагүйн эрхэнд гэр орон, эх орноо орхин гарч буй иргэдийг эрдэмтэн, судлаачид экологийн дүрвэгсэд гэсэн нэр томьёо, агуулгаар хэрэглэж байна.

Мөн экологийн дүрвэлт гэх ойлголтыг зарим улс орнууд цагаачлах гэж үзэх явдал ч байдаг.

Зураг 5. Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн байгалийн аюулт үзэгдэл



Аюулт үзэгдлүүд буюу газар хөдлөлт, тахалт өвчний улмаас оршин суугаа газар нутгаа орхихоос өөр гарцгүй болгож байгаа дүрвэгсдийг “цагаач” гэх нэр томьёололд оруулах нь учир дутагдалтай болж, ойрын ирээдүйд олон улсын эрх зүйд “Дүрвэгсэд”-ийн ангилалд оруулах төлөвтэй байна.

Манай улсын нутаг дэвсгэрт дүрвэгсэд орж ирэх нь олон улс, бүс нутаг, хил залгаа улсад үүсэх нөхцөл байдлаас ихээхэн хамаарах бөгөөд дүрвэгсдийн улмаас үүсэх нөхцөл байдал, эрх зүйн орчин, бодлого чиглэлийг тодорхойлох шаардлага зүй ёсоор тулгарч байна.

3.2. Монгол Улсад дүрвэгсэдтэй холбоотой үүсэж болзошгүй нөхцөл байдал, төрөөс баримтлах бодлого

ОХУ, Украины асуудалтай холбоотойгоор ОХУ 2022 онд дайчилгаа зарласнаас үүдэн оросын нутаг дэвсгэрээс олон мянган иргэд Монгол Улсын хилээр хууль ёсоор нэвтрэн орж ирсэн ч тэдгээрийн дийлэнх нь дайн дажин, цэрэг татлагаас зугтсан энгийн иргэд байх магадлалтай байна.

Үүнээс улбаалан хэрвээ дүрвэгсэд улсын хил дээр хэдэн зуу, мянгаараа бөөнөөрөө орж ирэхэд төрийн холбогдох байгууллагууд,

тухайлбал, цагаачлалын алба, тусгай алба, хилийн алба бэлэн байх шаардлага урган гарч байна. Хамгийн эхэнд улсын хил дээр үүрэг гүйцэтгэж буй хилийн цэргийн анги, салбарын бие бүрэлдэхүүн, хилийн хяналтын байгууллагууд үүрэг хүлээх болно.

Хил хамгаалах байгууллагын хувьд хууль тогтоомжид заагдсан эрх хэмжээний хүрээнд улсын хил дээр тухайн иргэдийг тогтоон барих, хилийн боомтоор хил нэвтрэх эрхийн баримт бичгийг үндэслэн улсын хилээр нэвтрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Харин дүрвэгсдийн асуудлаар зохицуулсан үйл ажиллагааны дүрэм, журам одоогоор байхгүй байна.

Ийм нөхцөл байдал үүссэн үед тэднийг хэн гэж тодорхойлох, хэрхэн ажиллах зэрэг асуулт ар араасаа гарч ирэх болно. Цаашдаа олон улсын болон үндэсний эрх зүйн зарчмаар дүрвэгсдийг улсын хил зөрчсөн, зөрчөөгүй, улс төрийн орогнол хүсэгч гэх мэтээр статусыг нь тодорхойлох нарийн, төвөгтэй асуудалтай тулгарах төлөвтэй байна.

Олон улсын эрх зүйн хүрээнд гол баримтлах 1948 оны НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тогтоолоор баталсан “Хүний эрхийн түгээмэл тунхаглал”-ын 13 дугаар зүйлд “Хэн боловч улсынхаа дотор чөлөөтэй зорчих, оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхтэй; Хэн боловч аливаа улс орныг, түүний дотроо эх орноо орхин явах, эх орондоо эргэж очих эрхтэй” гэж заасан. Гэвч дүрвэн ирж байгаа хүнийг хүлээн авахыг улс орнуудад үүрэг хүлээлгэсэн заалт байхгүй байна. Тэгэхээр дүрвэгсэдтэй холбоотой олон улсын конвенцод нэгдээгүй, үүрэг хүлээгээгүй улсын хувьд өөрийн үндэсний аюулгүй байдлыг хангах, эрх ашгаа хамгаалах хүрээнд дүрвэгсдийг хүлээн авах эсэх шийдвэрээ бие даан гаргах нь нээлттэй байна.

Мөн түүнчлэн олон улсын туршлагаас харахад дүрвэгсдийн дунд террорист, хүүхэд цэрэг (child soldier), гэмт хэрэгтэн, бүлэглэлүүд халхавчаар орж ирэх магадлал өндөр байдаг. Дүрвэгсдийн эмзэг байдлыг ашиглан хүний наймааны хохирогч болгох, улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон, хязгаарласан эд зүйлийг тээвэрлэгч болгох зорилгоор дүрвэгсэд ашиглагдахыг үгүйсгэх аргагүй юм.

Монгол Улсын оршин буй бүс нутаг дахь их гүрнүүдийн хооронд геополитикийн зөрчил улам бүр хурцадсан, “шинэ хүйтэн дайн”-ны нөхцөл байдал үүсээд байгаа өнөө үед дүрвэгсдийн үндэсний

аюулгүй байдалд учруулах аюул эрсдэл, цаашид авах арга хэмжээ, бодлого, төлөвлөлтөд анхаарлаа хандуулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Үүссэн нөхцөл байдалд нэн даруй ямар шуурхай хариу арга хэмжээг авах, үүнд зохих байгууллагууд ямар үүрэг оролцоотой, үйл ажиллагаа нь ямар уялдаатай байх, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ нь олон улсын болон дотоодын бодлого, хууль эрх зүйн аливаа зөрчилгүй байх, Монгол Улсын аюулгүй байдлын болон гадаад бодлогын зарчимтай уялдсан, эрх ашигт нийцсэн гэх зэрэг олон шалгуурыг хангах шаардлагатай.

Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар аливаа гадаадын иргэний эрх, үүргийг Монгол Улсын хууль, тухайн иргэний харьяалсан улстай байгуулсан гэрээгээр тогтоож, үзэл бодол, улс төрийн хийгээд шударга ёсны бусад үйл ажиллагааныхаа улмаас хавчигдан мөшгөгдсөн гадаадын иргэн, харьяалалгүй хүн үндэслэл бүхий хүсэл гаргавал Монгол Улсад орогнох эрх олгох боломжтой.

Хэрвээ Монгол Улсын хилээр орж ирж байгаа хүн өөрийн улс оронд ямар нэгэн байдлаар хүний эрх эрх чөлөө нь ноцтой зөрчигдөх, улс төрийн үзэл бодол, арьс өнгө, шашин шүтлэгээрээ ялгаварлан гадуурхагдах үндэслэл байвал Монгол Улсад «оргнол хүсэх» эрхээр хангах бодлого баримталж байна.

Түүнчлэн Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хүний салшгүй эрхээс бусад эрхийн хувьд үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд хуулиар зохих хязгаарлалт тогтоосон.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3-р зүйлийн 3.1.3.5-д: “Гадаадын иргэн, харьяалалгүй хүн, цагаачдын тооны зохист түвшнийг хадгалж, бүртгэл, мэдээллийн тогтолцоо, эрх зүйн орчин, удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгоно” хэмээн тусгасан нь үндэсний хүн ам зүйн бодлоготой холбоотой.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3-р зүйлийн 3.1.2.3-д: “Гаднын дүрвэгсэд олноор хил даван орж ирэх, гэнэтийн хяналтгүй нөхцөл байдал үүсэхээс сэргийлэх бэлэн байдлын тогтолцоог бүрдүүлж, эрх зүй, улс төр, дипломатын цогц

арга хэмжээ авна” хэмээн заасан нь дүрвэгсдийн улмаас үүсэж болзошгүй аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний бодлого төлөвлөлт бэлэн байдал зайлшгүй шаардлагатайг тодорхойлж байна.

Олон улсын туршлага сургамжаас ажиглахад, их хэмжээгээр удаан хугацаагаар дүрвэгсэд орж ирэн нутагшиж, суурьшиж, иргэншсэн тохиолдолд дараах аюул, эрсдэлийг тухайн улс оронд учруулж болзошгүй юм. Үүнд:

- Нийгмийн давхарга, үндсэн хүн амын бүтцэд өөрчлөлт оруулж, улмаар тэдний зүгээс үндсэрхэх, гадуурхах, үзэн ядах, хэт даврах үзлийг дэвэргэх хөрс суурь болох;
- Дүрвэгсэд үндэс угсаа, хэл соёл, арьс өнгө, шашин шүтлэгээрээ үндсэн хүн амаас ялгаран олон мянган жилийн турш төлөвшүүлж бий болгосон нийгмийн үнэт зүйлсийг үгүй болгох;
- Хүн амын хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамж, ахуй хангалтын тогтолцоонд өөрчлөлт оруулах;
- Тодорхой мэргэжилгүй, хямд ажиллах хүчний урсгалыг бий болгох, хөрөнгө чинээ, амьжиргааны түвшин, баян хоосны ялгааг улам гааруулах замаар нийгмийн давхаргын ялгарал үүсгэж улс оронд тогтворгүй байдлыг бий болгох;
- Гэмт хэргийн гаралт, эрүүгийн нөхцөл байдлыг хүндрүүлэх, төр засгийн удирдлагыг булаан авахыг оролдох, бослого, үймээн дэгдээх;
- “гарал үүсэл, удам угсаа нь тодорхойгүй хүмүүс” улс орны нэр хүндийг унагах, хууль ёсны ба хууль бус аргуудаар эрх ашгаа хамгаалах оролдлогуудыг хийх зэрэг багтаж байна.

Тухайлбал, үндэс угсаа, шашин шүтлэгээрээ нэгдсэн хэт даврагч бүлэглэлүүд үймээн самуун дэгдээн, тухайн улс орны төр засгийг хүчгүйдүүлж, хууль үйлчлэх боломжгүй болгож байгаа жишээг өнгөрсөн жил Франц, Герман болон Европын бусад оронд болсон дүрвэгсдийн асуудалтай холбоотой гашуун сургамжаас харж болно.

ДҮГНЭЛТ

Дүрвэгсдийн асуудал нь хүний эрхийг дээдэлсэн дэлхийн нийтийн тулгамдсан асуудал боловч хүн ам цөөн, газар нутаг том Монгол Улсын хувьд үндэсний аюулгүй байдлыг хангах асуудал ямагт дээгүүр тавигдах ёстой юм.

Хэдийгээр НҮБ тэргүүтэй олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс Монгол Улсыг дүрвэгсдийн олон улсын гэрээ конвенцод нэгдэхийг удаа дараа ятгаж, уриалж байгаа боловч тэдгээрт элсэх эсэх асуудлаар судалгаа хийх, олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлэх нь зүйтэй.

Одоогоор Монгол Улсад дүрвэгсдийн асуудлыг үндэсний хууль тогтоомж, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын бусад эрх зүйн гэрээгээр зохицуулж байна.

Монгол Улсад түгээмэл тохиолдох ган зуд цөлжилт зэрэг байгаль цаг уурын өөрчлөлтөөс үүдэлтэй дотоодын дүрвэгсдийн асуудал ойрын жилүүдэд хурцаар тавигдаж болзошгүй байна.

Мөн алсын ирээдүйд дэлхийн дулаарал, хэт халалт, далайн түвшин нэмэгдэх зэргээс үүдэлтэй экологийн дүрвэгсэд арлын орнууд, экваторын бүсийн орнуудаас Монгол Улсыг чиглэх магадлал бий.

Дүрвэгсэд их хэмжээгээр орж ирсэн тохиолдолд авах арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөөг тодотгох, үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын сөрөн тэсвэрлэх чадавхыг бүрдүүлэх, дээшлүүлэх шаардлагатай байна.

Ялангуяа дүрвэгсэд орж ирэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.1.2.3-д дурдсан: “Гаднын дүрвэгсэд олноор хил даван орж ирэх, гэнэтийн хяналтгүй нөхцөл байдал үүсэхээс сэргийлэх бэлэн байдлын тогтолцоог бүрдүүлж, эрх зүй, улс төр, дипломатын цогц арга хэмжээ авна” гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлж, ийм нөхцөл

байдал үүсэхэд хийгдэх хариу арга хэмжээний бодлого төлөвлөлтөд төрийн байгууллага, бие бүрэлдэхүүнийг сургаж, дадлагажуулж бэлэн байдлыг хангахад онцгойлон анхаарах нь зүйтэй.

Ашигласан материал:

1. Хүний эрхийн түгээмэл тунхаглал. 1948 он
2. Хүүхдийн эрхийн конвенц. 1990 он
3. Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай конвенц. 1951 он
4. Дипломат харилцааны тухай Венын конвенц. 1961 он
5. Дүрвэгсдийн тухай Картагенийн тунхаглал. 1984 он
6. Монгол улсын Үндсэн хууль. 1992 он
7. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. 2010 он
8. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль. 2010 он

Хавсралт

1951 ОНЫ ДҮРВЭГСДИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ КОНВЕНЦ

(албан бус товчилсон орчуулга)

УДИРТГАЛ

Хэлэлцэн тохирогч талууд

1948 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Ерөнхий Ассамблейгаас баталсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэм, Хүний эрхийн түгээмэл тунхаглалд бүх хүн аливаа төрлийн ялгаварлан гадуурхахгүйгээр үндсэн эрх, эрх чөлөөг эдэлнэ гэсэн зарчмыг тогтоосонтой холбогдуулан:

- НҮБ дүрвэгсдийн хувь заяаны талаар гүн гүнзгий сонирхож байгаагаа олон удаа илэрхийлж, дүрвэгсдэд эдгээр үндсэн эрх, эрх чөлөөг аль болох өргөнөөр эдлүүлэхийн тулд хүчин чармайлт гаргасаар ирснийг харгалзан үзэж;
- Дүрвэгсдийн эрх зүйн байдлын талаар олон улсын гэрээ байгуулж, тэдгээр гэрээний хамрах хүрээ, үзүүлэх хамгаалалтыг шинэ гэрээ байгуулах замаар өргөжүүлэхийн тулд орогнох эрх олгох нь зарим улс оронд үндэслэлгүй дарамт учруулж болзошгүйг анхаарч;
- НҮБ-аас хүлээн зөвшөөрсөн олон улсын цар хүрээ, шинж чанартай асуудлыг олон улсын хамтын ажиллагаагүйгээр шийдвэрлэх боломжгүй бөгөөд бүх улс дүрвэгсдийн асуудлын нийгэм, хүмүүнлэгийн мөн чанарыг хүлээн зөвшөөрч, улс хоорондын зөрчилдөөнөөс урьдчилан сэргийлэхийн тулд бүх арга хэмжээг авахыг хүсэж;

- НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн дээд комиссар дүрвэгсдийг хамгаалах олон улсын конвенцын хэрэгжилтэд хяналттавиx үүрэгтэйг дурдаад, энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд авч буй арга хэмжээний уялдаа холбоо үр дүнтэй байх нь дүрвэгсдийн хамтын ажиллагаанаас хамаарна гэдгийг хүлээн зөвшөөрч дараах гэрээг байгуулав.

I БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. “Дүрвэгч” гэсэн ойлголтын тодорхойлолт

1. Арьс өнгө, шашин шүтлэг, иргэний харьяалал, нийгмийн тодорхой бүлгийн гишүүн, улс төрийн үзэл бодлын улмаас мөрдлөгө хавчлагад өртөнө гэж бүрэн үндэслэлтэй болгоомжилж буйн учир харьяат орныхоо хамгаалалтыг эдэлж чадахгүй буюу дээрх болгоомжлолын улмаас эдлэхийг хүсэхгүй байгаа, эсвэл, иргэний харьяалалгүй бөгөөд тийм хэрэг явдлын улмаас өөрийн өмнө нь хэвийн оршин сууж байсан орноос гадна байгаа болон дээрх болгоомжлолын үүднээс буцаж чадахгүй буюу буцахыг хүсэхгүй байгаа хүнийг хэлнэ.

2. Энэхүү конвенцын заалтууд нь энх тайвны эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэн гэж үзэх ноцтой үндэслэл байгаа бүх хүнд хамаарахгүй.

2 дугаар зүйл. Нийтлэг үүрэг

Дүрвэгч бүр өөрийн амьдарч буй улс орны өмнө үүрэг хүлээдэг бөгөөд үүний дагуу тэрээр хууль, тогтоомж, дүрэм, журам, түүнчлэн нийгмийн хэв журмыг сахиулах арга хэмжээг дагаж мөрдөх ёстой.

3 дугаар зүйл. Ялгаварлан гадуурхахгүй байх

Хэлэлцэн тохирогч улсууд энэхүү конвенцын заалтыг дүрвэгсдэд арьсны өнгө, шашин шүтлэг, гарал үүслээр нь ялгаварлан гадуурхахгүйгээр хэрэглэнэ.

4 дүгээр зүйл. Шашны итгэл үнэмшил

Хэлэлцэн тохирогч улсууд өөрийн нутаг дэвсгэрт байгаа дүрвэгсдэд шашин шүтэх эрх чөлөө, үр хүүхэддээ шашны боловсрол олгох эрх чөлөөг хангах үүднээс өөрийн иргэдтэй адил нааштай байр суурь олгоно.

5 дугаар зүйл. Энэхүү конвенцоос үл хамааран олгогдсон эрхүүд

Энэхүү конвенцын аль ч заалт нь Хэлэлцэн тохирогч аливаа улсаас энэхүү конвенцоос үл хамааран дүрвэгсдэд олгосон эрх, тэтгэмжийг хөндөхгүй.

6 дугаар зүйл. “Ижил нөхцөл байдалд” гэсэн хэллэг

Энэхүү конвенцод “ижил нөхцөл байдалд” гэсэн хэллэгээр, дүрвэгч нь тухайн улсад байх, оршин суух хугацаа, нөхцөлтэй холбоотой шаардлагуудыг хангах ёстой гэсэн үг юм.

7 дугаар зүйл. Харилцан үйлчлэх зарчмаас үл хамаарах зүйлүүд

1. Энэхүү конвенцын дагуу дүрвэгсдэд илүү таатай эрх зүйн статус олгохоос бусад тохиолдолд Хэлэлцэн тохирогч улс тэдэнд гадаадын иргэний нийтлэг эдлэх статусыг олгоно.

2. Хэлэлцэн тохирогч улсын нутаг дэвсгэрт гурван жил оршин суух хугацаа дуусахад бүх дүрвэгсэд хуулиар тогтоосон харилцан үйлчлэх шаардлагаас чөлөөлөгдөнө. Хэлэлцэн тохирогч улс бүр дүрвэгсдэд олгогдсон эрх, ашиг тусыг нь үргэлжлүүлэн олгоно.

8 дугаар зүйл. Онцгой арга хэмжээнээс чөлөөлөх

Гадаад улсын иргэдийн эд хөрөнгө, ашиг сонирхолд хэрэглэж болох онцгой арга хэмжээг Хэлэлцэн тохирогч улсууд зөвхөн иргэний харьяаллаар нь тухайн улсын албан ёсоор иргэн болсон дүрвэгсдэд хэрэглэхгүй. Энэ зүйлд заасан ерөнхий зарчмыг хэрэглэхийг хууль тогтоомж нь зөвшөөрөөгүй Хэлэлцэн тохирогч улсууд зохих тохиолдолд дүрвэгсдийн ашиг тусын тулд чөлөөлнө.

9 дүгээр зүйл. Түр арга хэмжээ

Хэлэлцэн тохирогч улсыг дайны үед болон бусад онцгой нөхцөл байдал үүссэн үед тухайн хүнтэй холбоотой үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхлын үүднээс шаардлагатай гэж үзсэн түр арга хэмжээг авах эрхийг энэхүү конвенцоор хасаж болохгүй.

10 дугаар зүйл. Оршин суух тасралтгүй байдал

1. Дүрвэгчийг дэлхийн II дайны үед албадан гаргаж, Хэлэлцэн тохирогч аль нэг улсын нутаг дэвсгэрт илгээсэн бөгөөд тэнд оршин

сууж байгаа бол албадан оршин суух хугацааг тухайн нутаг дэвсгэрт хууль ёсоор оршин сууж байсан цаг гэж үзнэ.

2. Дүрвэгчийг дэлхийн II дайны үед Хэлэлцэн тохирогч аль нэг улсын нутаг дэвсгэрээс албадан гаргаж, энэхүү конвенц хүчин төгөлдөр болохоос өмнө тэнд байнгын оршин суух газар тогтоох зорилгоор нутаг буцаасан бол түүнийг албадан гаргахаас өмнө болон дараа нь оршин сууж байсан хугацааг байнга оршин суусан тасралтгүй хугацаа гэж үзнэ.

11 дүгээр зүйл. Дүрвэгч далайчид

Хэрэв дүрвэгсэд нь Хэлэлцэн тохирогч аль нэг улсын далбаа мандуулсан хөлөг онгоцны багийн бүрэлдэхүүнд ихэвчлэн ажилладаг далайчид байвал тухайн улс тэднийг нутаг дэвсгэртээ нааштай суурьшуулж, тэдэнд аяллын бичиг баримт олгох, эсхүл өөрийн улсын хилээр түр нэвтрэх эрхийг олгоно.

II БҮЛЭГ. ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ

12 дугаар зүйл. Хувийн байдал

1. Дүрвэгчийн хувийн байдлыг тухайн улсынхаа хууль тогтоомжоор, хэрэв байхгүй бол оршин суугаа улсынхаа хуулиар тогтоодог.

2. Дүрвэгчийн хувийн байдалтай холбогдуулан урьд нь олж авсан эрх, ялангуяа гэрлэлтийн улмаас үүссэн эрхийг Хэлэлцэн тохирогч улсууд шаардлагатай бол тухайн улсын хууль тогтоомжоор тогтоосон албан ёсны шаардлагыг хангасан тохиолдолд хүндэтгэнэ.

13 дугаар зүйл. Хөдлөх ба үл хөдлөх хөрөнгө

Хөдлөх, үл хөдлөх хөрөнгө болон түүнтэй холбоотой бусад эрх олж авах, түүнчлэн хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой түрээсийн болон бусад гэрээний хувьд Хэлэлцэн тохирогч улсууд дүрвэгсдэд аль болох таатай байр суурь олгоно.

14 дүгээр зүйл. Зохиогчийн эрх ба үйлдвэрлэлийн эрх

Зохиол, зураг, загвар, барааны тэмдэг, компанийн нэр, утга зохиол, урлаг, шинжлэх ухааны бүтээлийн эрх зэрэг үйлдвэрлэлийн эрхийг хамгаалахын тулд дүрвэгсэд оршин суугаа тухайн улсын иргэдтэй адил хамгаалалтад хамрагдана. Хэлэлцэн тохирогч бусад

улсын нутаг дэвсгэрт тэд байнга оршин сууж байгаа бол тухайн нутаг дэвсгэрт тухайн улсын иргэдэд олгодогтой адил хамгаалалтад хамрагдана.

15 дугаар зүйл. Нэгдэх эрх

Улс төрийн шинж чанартай, ашиг хонжоо хайдаггүй холбоод, үйлдвэрчний эвлэлийн тухайд Хэлэлцэн тохирогч улсууд өөрсдийн нутаг дэвсгэрт хууль ёсоор оршин суугаа дүрвэгсдэд гадаад улсын иргэдийнхтэй адил ижил нөхцөлд хамгийн таатай байр суурийг олгоно.

16 дугаар зүйл. Давж заалдах эрх

1. Дүрвэгч бүр Хэлэлцэн тохирогч бүх улсын нутаг дэвсгэр дэх шүүхэд үнэ төлбөргүй хандах эрхтэй.

2. Дүрвэгч бүр өөрийн байнга оршин сууж байгаа Хэлэлцэн Тохирогч Улсын нутаг дэвсгэрт шүүхэд хандах эрхийн хувьд, ялангуяа хууль зүйн туслалцаа авах, аюулгүй байдлыг хангах, шүүхийн зардлыг төлөхөд тухайн улсын иргэдтэй адил харилцааг эдэлнэ.

III БҮЛЭГ. ОРЛОГО ОЛОХ

17 дугаар зүйл. Хөдөлмөр эрхлэлт

1. Хэлэлцэн тохирогч улсууд нутаг дэвсгэртээ хууль ёсоор оршин суугаа дүрвэгсдэд хөдөлмөр эрхлэх эрхийнх нь хувьд гадаад улсын иргэдэд эдлэх ижил нөхцөл байдалд эрх зүйн хамгийн таатай байр суурийг олгоно.

2. Энэхүү конвенц хүчин төгөлдөр болсон өдөр эдгээр арга хэмжээнд хамрагдаагүй дүрвэгсдэд хөдөлмөрийн дотоод зах зээлийг хамгаалах зорилгоор хэрэглэсэн гадаадын иргэн, гадаадын иргэнийг ажиллуулахтай холбоотой хязгаарлалтын арга хэмжээ ямар ч тохиолдолд хамаарахгүй.

18 дугаар зүйл. Өөрийн аж ахуйн нэгжид ажил эрхлэх

Хэлэлцэн тохирогч улсууд өөрсдийн нутаг дэвсгэрт хууль ёсоор оршин сууж буй дүрвэгсдэд хамгийн таатай хууль эрх зүйн байр

суурийг, ямар ч тохиолдолд гадаадын иргэдийн хувийн аж ахуй эрхлэх эрхтэй адил нөхцөл байдалд эдэлж буй нөхцөл байдлаас багагүй таатай нөхцөлөөр хангана.

19 дүгээр зүйл. Чөлөөт мэргэжлүүд

1. Хэлэлцэн тохирогч улс бүр өөрийн нутаг дэвсгэрт хууль ёсоор оршин суудаг, тухайн улсын эрх бүхий байгууллагаас хүлээн зөвшөөрсөн зэрэгтэй, чөлөөт мэргэжлээр ажиллах хүсэлтэй дүрвэгсдэд хамгийн таатай эрх зүйн байр суурь, ямар ч тохиолдолд гадаадын иргэдийн түгээмэл ашигладагтай ижил нөхцөл, түүнээс багагүй нөхцөл байдал олгоно.

2. Хэлэлцэн тохирогч улсууд дүрвэгсдийг олон улсын харилцааг нь хариуцдаг бүсээс бусад нутаг дэвсгэрт байршуулах боломжийг бүрдүүлэхийн тулд хууль тогтоомж, үндсэн хуулиараа зөвшөөрсөн бүх арга хэмжээг авна.

IV БҮЛЭГ. НИЙГМИЙН ХАЛАМЖ

20 дугаар зүйл. Хоол тэжээлийн тогтолцоо

Хүнсний хомсдолтой, хүнсний ерөнхий хуваарилалтыг зохицуулдаг нийт хүн амын хоолны дэглэмийн тогтолцоо байгаа тохиолдолд дүрвэгсдэд иргэдтэй адил тэгш эрхтэйгээр үйлчилнэ.

21 дүгээр зүйл. Орон сууцны асуудал

Орон сууцны асуудлыг хууль, журмаар зохицуулдаг эсвэл төрийн эрх мэдлийн хяналтад байдаг тул Хэлэлцэн тохирогч улсууд өөрсдийн нутаг дэвсгэрт хууль ёсоор оршин сууж буй дүрвэгсдэд хамгийн таатай хууль эрх зүйн байр суурийг, ямар ч тохиолдолд гадаадын иргэдээс дутуугүй нөхцөлөөр хангана.

22 дугаар зүйл. Олон нийтийн боловсрол

1. Бага боловсролын тухайд Хэлэлцэн тохирогч улсууд дүрвэгсдэд иргэнийхтэй адил эрх зүйн статус олгоно.

2. Бага боловсролоос бусад төрийн боловсролын төрөл, ялангуяа суралцах боломжийн хувьд гадаад улсын гэрчилгээ, диплом, зэргийг хүлээн зөвшөөрөх, суралцах эрх, хураамжаас чөлөөлөх, түүнчлэн Хэлэлцэн тохирогч улсууд тэтгэлэг олгохтой холбогдуулан дүрвэгсдэд хууль эрх зүйн илүү таатай байр суурь,

ямар ч тохиолдолд ижил нөхцөл байдалд гадаадын иргэдийн эдэлж байгаа байр сууринаас дутуугүй таатай нөхцөл олгоно.

23 дугаар зүйл. Засгийн газрын тусламж

Хэлэлцэн тохирогч улсууд нутаг дэвсгэртээ хууль ёсоор оршин сууж буй дүрвэгсдэд төрөөс үзүүлэх тусламж, тусламжийн хувьд тэдний иргэдэд үзүүлдэгтэй адил зохицуулалт үзүүлнэ.

24 дүгээр зүйл. Хөдөлмөрийн тухай хууль ба нийгмийн хамгаалал

1. Хэлэлцэн тохирогч улсууд өөрийн нутаг дэвсгэрт хууль ёсоор оршин сууж буй дүрвэгсдэд ажлын цаг, илүү цагаар, цалинтай амралт, гэрээр ажиллах хязгаарлалт, ажилчдын насны доод хязгаар зэрэг асуудлаар иргэдтэй адил харилцааг тогтооно.

2. Дүрвэгсдийн ажлын осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас нас барсны нөхөн төлбөр авах эрх нь хангагдана.

3. Хэлэлцэн тохирогч улсууд дүрвэгсдэд нийгмийн хамгааллын талаар олж авах явцад олж авсан эрх, эрхээ хадгалахын тулд тэдний хооронд байгуулсан эсвэл байгуулж болох гэрээ хэлцлээс үүсэх тэтгэмжийг гагцхүү дүрвэгсдэд олгоно.

V БҮЛЭГ. ЗАХИРГААНЫ АРГА ХЭМЖЭЭ

25 дугаар зүйл. Захиргааны дэмжлэг

1. Дүрвэгсэд аливаа эрхээ хэрэгжүүлэхэд гадаад улсын эрх баригчдын тусламж шаардлагатай ч тухайн дүрвэгсэд хандах боломжгүй бол тухайн дүрвэгсэдийн нутаг дэвсгэрт нь оршин суугаа Хэлэлцэн тохирогч улсууд, эрх бүхий байгууллагууд тэдэнд ийм тусламж үзүүлэх ажлыг зохион байгуулна.

2. 1-д эрх бүхий байгууллага дүрвэгсдийг хангах буюу тэдгээрийн хяналтан дор дүрвэгсдэд харьяалагдаж байгаа улсынхаа эрх бүхий байгууллагаас гадаадын иргэдэд олгодог бичиг баримт, гэрчилгээг хангана.

3. Энэ журмаар олгосон баримт бичиг, гэрчилгээ нь гадаадын иргэнд харьяалагддаг улсын эрх бүхий байгууллага буюу эрх бүхий байгууллагаас олгосон албан ёсны баримт бичгийг орлож, хүчин төгөлдөр бус болох нь нотлогдох хүртэл хүчинтэйд тооцогдоно.

4. Төлбөрийн чадваргүй хүмүүст олгосон тусгай тэтгэмжээс бусад тохиолдолд энэ зүйлд заасан үйлчилгээний төлбөрийг авч болно. Харин ийм хураамж нь дунд зэрэг байх бөгөөд ижил төрлийн үйлчилгээ үзүүлсний төлөө иргэдээс авах төлбөртэй тохирно.

26 дугаар зүйл. Шилжилт хөдөлгөөний эрх чөлөө

Хэлэлцэн тохирогч улс бүр өөрийн нутаг дэвсгэрт байгаа дүрвэгсдэд хууль ёсны дагуу оршин суух газраа сонгох, нутаг дэвсгэртээ чөлөөтэй зорчих эрхийг гадаадын иргэдийн ижил нөхцөл байдалд ерөнхийд нь хамаарах бүх дүрэм журмын дагуу олгоно.

27 дугаар зүйл. Хувийн (иргэний) үнэмлэх

Хэлэлцэн тохирогч улсууд өөрийн нутаг дэвсгэрт байгаа, хүчинтэй аяллын бичиг баримтгүй дүрвэгсдэд хувийн (иргэний) үнэмлэх олгоно.

28 дугаар зүйл. Аяллын бичиг баримт

1. Хэлэлцэн тохирогч улсууд өөрийн нутаг дэвсгэрт хууль ёсоор оршин суугаа дүрвэгсдэд үндэсний аюулгүй байдал, нийтийн хэв журам сахиулах хүндэтгэн үзэх шалтгаан нь үүнд саад болохгүй бол өөрийн нутаг дэвсгэрээс гадуур зорчихоор аяллын бичиг баримт олгоно.

2. Олон улсын хуучин гэрээний дагуу талуудаас дүрвэгсдэд олгосон аяллын бичиг баримтыг Хэлэлцэн тохирогч улсууд энэ зүйлийн дагуу олгосонтой адил хүлээн зөвшөөрч, харьцана.

29 дүгээр зүйл. Татвар

1. Хэлэлцэн тохирогч улсууд дүрвэгсдээс ижил төстэй нөхцлөөр өөрсдийнх нь иргэдээс ногдуулж болох татвараас өөр буюу түүнээс их татвар, хураамж, татвар ногдуулахгүй.
2. Өмнөх хэсгийн заалтууд нь дүрвэгсдэд гадаадын иргэдэд захиргааны бичиг баримт, түүний дотор хувийн (иргэний) үнэмлэх олгохтой холбоотой хууль тогтоомжийг хэрэглэхэд ямар нэгэн байдлаар саад болохгүй.

30 дугаар зүйл. Эд хөрөнгийг гадагш авч гарах

1. Хэлэлцэн тохирогч улсууд өөрсдийн хууль тогтоомжийн дагуу дүрвэгсдэд тухайн улсын нутаг дэвсгэрт авчирсан эд хөрөнгөө нэвтрэх эрх олгосон өөр улс руу гадагш авч гарахыг зөвшөөрнө.

2. Хэлэлцэн тохирогч улсууд дүрвэгсдийн орох эрх олгосон бусад улсад суурьшихад шаардлагатай эд хөрөнгөө гадаадад гаргах зөвшөөрөл хүссэн өргөдлийг тухайн эд хөрөнгө хаана ч байсан нааштай хандана.

31 дүгээр зүйл. Орогнол хүссэн улсад хууль бусаар байгаа дүрвэгсэд

1. Хэлэлцэн тохирогч улсууд 1 дүгээр зүйлд заасны дагуу амь нас, эрх чөлөөнд нь заналхийлсэн нутаг дэвсгэрээс шууд ирсэн дүрвэгсдийг нутаг дэвсгэртээ хууль бусаар нэвтэрсэн буюу хууль бусаар оршин суусан тохиолдолд шийтгэл оногдуулахгүй.

2. Хэлэлцэн тохирогч улсууд тэдний зорчих эрх чөлөөг шаардлагагүй хязгаарлалтаар хязгаарлахгүй. Ийм хязгаарлалт нь эдгээр дүрвэгсдийн тухайн улс дахь статусыг тогтворжуулах эсвэл өөр улсад нэвтрэх эрх олгох хүртэл л хамаарна. Хэлэлцэн тохирогч улсууд эдгээр дүрвэгсдэд өөр улс руу нэвтрэх эрхийг хангах хангалттай хугацаа, шаардлагатай бүх нөхцөлийг олгоно.

32 дугаар зүйл. Хөөх

1. Хэлэлцэн тохирогч улсууд өөрийн нутаг дэвсгэрт хууль ёсоор оршин сууж буй дүрвэгсдийг үндэсний аюулгүй байдал, нийтийн хэв журам хамгаалах шалтгаанаас бусад тохиолдолд албадан гаргахгүй.

2. Ийм дүрвэгсдийг албадан гаргах нь зөвхөн шүүхийн шийдвэрийн дагуу явагдана. Үндэсний аюулгүй байдлын хүндэтгэн үзэх шалтгаан саад болохгүй бол дүрвэгсдэд өмгөөлөлдөө нотлох баримт гаргах, зохих байгууллагад, эсхүл зохих байгууллагаас тусгайлан томилсон хүн, хүмүүст давж заалдах, энэ зорилгоор төлөөлөгчдөө оролцуулах эрхийг олгоно.

3. Хэлэлцэн тохирогч улсууд эдгээр дүрвэгсдэд өөр улсад нэвтрэх хууль ёсны эрх олж авах боломжийн хугацааг олгоно. Хэлэлцэн тохирогч улсууд энэ хугацаанд шаардлагатай гэж үзсэн дотоод арга хэмжээг хэрэглэх эрхтэй.

33 дугаар зүйл. Дүрвэгсдийг ирсэн улс руу нь албадан гаргахыг хориглох

1. Хэлэлцэн тохирогч улсууд дүрвэгсдийг тэдний амьдрал, нийгмийн бүлэг, улс төрийн үзэл бодолд нь аюул учруулж буй улсын хил рүү ямар ч байдлаар гаргахгүй, буцаахгүй.

2. Гэсэн хэдий ч хүндэтгэн үзэх шалтгаанаар оршин суугаа улсынхаа аюулгүй байдалд заналхийлсэн гэж үзсэн, эсхүл онц хүнд гэмт хэрэг үйлдэж, албадан гүйцэтгэх ялаар шийтгүүлсэн дүрвэгсдэд энэ тогтоол хамаарахгүй.

34 дүгээр зүйл. Иргэний харьяалал

Хэлэлцэн тохирогч улсууд аль болох дүрвэгсдийг нутагшуулж, харьяат болгоход тус дөхөм үзүүлнэ. Ялангуяа иргэншил авах үйл явцыг хурдасгах, холбогдох хураамж, зардлыг бууруулахын тулд тэд чадах бүхнээ хийх болно.

VI БҮЛЭГ. ШИЛЖИЛТИЙН ҮЕИЙН КОНВЕНЦЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗҮЙЛС

35 дугаар зүйл. Үндэсний эрх баригчид болон НҮБ-ын хамтын ажиллагаа

1. Хэлэлцэн тохирогч улсууд НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн дээд комиссарын газар эсвэл түүний чиг үүргийг хэрэгжүүлэх НҮБ-ын бусад байгууллагатай хамтран ажиллах үүрэг хүлээнэ.

2. НҮБ-ын Дээд Комиссарын Газар эсвэл НҮБ-ын холбогдох байгууллагад тайлагнаж байх боломжийг олгохын тулд Хэлэлцэн тохирогч улсууд тэдэнд шаардлагатай статистик мэдээлэл, дүрвэгсдийн нөхцөл байдал, конвенцын хэрэгжилт, дүрвэгсдийн асуудалтай холбоотой хүчин төгөлдөр эсвэл дараа нь хүчин төгөлдөр болох хууль тогтоомж, журам, тогтоолуудыг зохих хэлбэрээр нийлүүлэх үүрэг хүлээнэ.

36 дугаар зүйл. Үндэсний болон хууль тогтоомжийн актуудын талаарх мэдээлэл

Хэлэлцэн тохирогч улсууд энэхүү конвенцыг хэрэгжүүлэх зорилгоор гаргасан хууль тогтоомжийн эх бичвэрийг НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад уламжилна.

37 дугаар зүйл. Өмнө нь байгуулсан конвенцууд

Энэхүү конвенцын 28 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу энэхүү конвенц нь талуудын хувьд 1922 оны 7-р сарын 5, 1924 оны 5-р сарын 31, 1926 оны 5-р сарын 12-ны актууд, 1933 оны 10-р сарын 28, 193 оны 2-р сарын 10-ны өдрийн актуудыг орлоно.

VII БҮЛЭГ. ТӨГСГӨЛИЙН ЗААЛТУУД

38 дугаар зүйл. Маргааныг шийдвэрлэх

Энэхүү конвенцыг тайлбарлах, хэрэглэхтэй холбоотой талуудын хооронд үүссэн, өөрөөр шийдвэрлэх боломжгүй бүх маргааныг маргагч талуудын аль нэгнийх нь хүсэлтээр Олон улсын шүүхэд өгнө.

39 дүгээр зүйл. Гарын үсэг зурах, соёрхон батлах, нэгдэн орох

1. Энэхүү конвенцыг 1951 оны долоодугаар сарын 28-ны өдөр Женевт гарын үсэг зурахад нээлттэй бөгөөд дараа нь НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулна. Энэ нь 1951 оны долоодугаар сарын 28-наас наймдугаар сарын 31-ний хооронд НҮБ-ын Европын албанд гарын үсэг зурахад нээлттэй байх бөгөөд 1951 оны есдүгээр сарын 17-ноос 1952 оны 12 дугаар сарын 31 хүртэл НҮБ-ын төв байранд дахин гарын үсэг зурахаар нээгдэнэ.

2. Энэхүү конвенц нь НҮБ-ын бүх гишүүн улс, түүнчлэн Дүрвэгсэд, харьяалалгүй хүмүүсийн байдлын асуудлаарх Бүрэн эрхт төлөөлөгчдийн бага хуралд оролцохоор уригдан ирсэн бусад улс, аль нэг улсын нэрийн өмнөөс гарын үсэг зурахад нээлттэй байна. Энэхүү конвенцыг соёрхон батлах ёстой бөгөөд батламж жуух бичгээ НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулна.

3. Энэхүү конвенц нь 1951 оны 7-р сарын 28-ны өдрөөс эхлэн энэ зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан улсууд нэгдэн ороход нээлттэй байна. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад нэгдэн орох тухай баримт бичгийг хадгалуулснаар нэгдэн орох болно.

40 дүгээр зүйл. Конвенцын нутаг дэвсгэрийн хэрэглээний тухай журам

1. Аливаа улс конвенцод гарын үсэг зурах, соёрхон батлах, нэгдэн орох үедээ энэхүү конвенц нь тухайн улс олон улсын харилцааг хариуцах бүх нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт хамаарна гэж мэдэгдэж болно. Ийм мэдэгдэл нь тухайн улсын хувьд конвенц хүчин төгөлдөр болсон өдрөөс хүчин төгөлдөр болно.

2. Конвенцын хугацааг сунгахыг хожим нь НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад илгээсэн мэдэгдлээр зарлах бөгөөд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга хүлээн авснаас хойш 90 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

3. Энэхүү конвенц гарын үсэг зурах, соёрхон батлах, нэгдэн орох үед хэрэгжээгүй нутаг дэвсгэрийн хувьд холбогдох улс бүр зөвшөөрснөөр эдгээр нутаг дэвсгэрт энэхүү конвенцын хэрэгжилтийг өргөжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг авах боломжтой эсэхийг авч үзэх болно.

41 дүгээр зүйл. Холбооны улсуудын нөхцөл

Дараах заалтыг холбооны болон нэгдмэл бус хэлбэрийн муж улсуудад хэрэглэнэ: а) энэхүү конвенцын бүрэлдэхүүн муж, кантонуудын хууль тогтоох эрх мэдэлд хамаарах зүйлүүдийн талаар Холбооны үндсэн хуулийн дэг журмын дагуу хууль тогтоох арга хэмжээ авахын тулд холбооны засгийн газар эдгээр зүйлд хамаарах муж, кантонуудын холбогдох эрх бүхий байгууллагад Конвенцын аливаа тодорхой заалттай холбоотой эерэг тайлбарыг аль болох эрт мэдэгдэх ёстой.

42 дугаар зүйл. Тайлбар

1. Конвенцын 1, 3, 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 33, 36-46 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг эс тооцвол аль ч улс гарын үсэг зурах, соёрхон батлах, нэгдэн орох үед конвенцын зүйлд тайлбар хийж болно.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу тайлбар хийсэн аль ч улс НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэх замаар хэдийд ч уг тайлбараа цуцалж болно.

43 дугаар зүйл. Хүчин төгөлдөр болох

1. Энэхүү конвенц нь нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулсан өдрөөс хойш 90 дэх өдөр хүчин төгөлдөр болно.

2. Нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулсны дараа конвенцыг соёрхон баталсан буюу нэгдэн орсон бүх улсын хувьд уг конвенц нь соёрхон батлах, эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулсан өдрөөс хойш 90 дэх өдөр хүчин төгөлдөр болно.

44 дүгээр зүйл. Цуцлах

1. Хэлэлцэн тохирогч аль ч улс НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад илгээсэн мэдэгдлээр хэдийд ч энэхүү конвенцыг цуцалж болно.

2. Ийм цуцлалт нь НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга

мэдэгдлийг хүлээн авснаас хойш нэг жилийн дараа холбогдох Хэлэлцэн тохирогч улсын хувьд хүчин төгөлдөр болно.

3. 40 дүгээр зүйлийн дагуу мэдэгдэл хийсэн аливаа улс үүнээс хойш хэдийд ч НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад хаягласан мэдэгдлээр уг конвенц нь тухайн нутаг дэвсгэрт нэг жилийн дараа үйлчлэхгүй гэдгийг мэдэгдэж болно.

45 дугаар зүйл. Шинэчилсэн найруулга

1. Хэлэлцэн тохирогч аль ч улс НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад хаягласан мэдэгдлээр хэдийд ч энэхүү конвенцод өөрчлөлт оруулах хүсэлт гаргаж болно.

2. Ийм хүсэлттэй холбогдуулан ямар нэгэн арга хэмжээ авах шаардлагатай бол НҮБ-ын Ерөнхий Ассамблей зохих арга хэмжээг авахыг зөвлөж байна.

46 дугаар зүйл. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын мэдэгдэл

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга НҮБ-ын бүх гишүүн болон гишүүн бус орнуудад үүнийг гэрчлэхийн тулд зохих ёсоор эрх олгогдсон Засгийн газруудаа төлөөлөн конвенцод гарын үсэг зурсан талаар мэдээлэх болно. Женев хотноо 1951 оны долоодугаар сарын 28-ны өдөр нэг хувь үйлдсэн англи, франц эх бичвэрүүд нь адилхан хүчинтэй. Энэ хуулбарыг НҮБ-ын архивт хадгалж, баталгаажуулсан хуулбарыг НҮБ-ын бүх гишүүн оронд шилжүүлнэ.